

ЗӨВШӨӨРӨВ:

ЭМЯ-НЫ ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ  
ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



..... Ц.ЭРДЭМБИЛЭГ

БАТЛАВ:

ЭМЯ-НЫ СУВИЛАХУЙН МЭРГЭЖЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



..... Г.ХУЛАН

*Гар бичмэлийн эрхтэй*

**СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН СУВИЛАХУЙН  
МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ,  
ХӨТӨЛБӨР**

УЛААНБААТАР  
2021

АШУУИС-ийн захирлын 2019 оны 05 сарын 27 ны  
А/187 тоот тушаалыг үндэслэв.



**АШУУИС**  
Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль  
1942

**БАТЛАВ:**

**АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ  
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ, ЭРДМИЙН  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**

..... **Н.ХҮРЭЛБААТАР**

УХД0074 5846459

2021 оны 01 дугаар сарын 04-ны өдөр

**СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН СУВИЛАХУЙН МЭРГЭШҮҮЛЭХ  
СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Салбар: Сувилахуйн ухаан  
Мэргэшлийн чиглэл: Сэтгэцийн Эрүүл Мэндийн сувилахуй  
Элсэгчдийн боловсролын түвшин: Диплом, бакалавр  
Сургалтын төрөл: Мэргэшүүлэх  
Сургалтын хэлбэр: Өдөр  
Сургалтын хугацаа: 6 сар  
Нийт багц цаг: 26 кредит

Д/Д	Хичээлийн нэр	Цаг				
		Бүгд		Үүнээс		
		Кредит	Цаг	Лекц	Семинар	Дадлага
<b>1. Заавал судлах хичээл</b>						
1.	Удиртгал					
<b>Бүгд</b>		<b>1</b>	<b>16</b>	<b>16</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>2. Мэргэшүүлэх хичээл</b>						
<b>Модуль I</b>						
2.	Сэтгэцийн эрүүл мэндийн тухай орчин үеийн ойлголт, түүхэн хөгжил			2	8	
3.	Сэтгэцийн эмгэг судлалын судлах зүйл ерөнхий ба тусгай сэтгэцийн эмгэг судлал, Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүтэц, зохион байгуулалт			2	8	
4.	Олон улсын түвшин дэх сэтгэцийн эрүүл мэндийн хууль эрх зүйн асуудлууд (хууль, бодлого, тунхаг, бодлогын баримт бичгүүд)			2	8	
5.	Монгол улс дахь Сэтгэцийн эрүүл мэндийн тусламжийн хууль эрхзүйн асуудлууд (хууль, бодлого, тунхаг, бодлогын баримт бичгүүд)			2	8	
6.	Сэтгэцийн эрүүл мэндийн бодлого боловсруулахад сувилагчийн оролцоо Сэтгэцийн эрүүл мэндийн бодлого болон үйлчилгээний чанарыг сайжруулах нь			2	8	

7.	Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээнд оролцогч талуудын ёс зүйн асуудлын чиг хандлага, урьдчилан сэргийлэлт			2	8	
8.	Сувилахуйн ёс зүй болон ёс зүйн код			2	8	
9.	Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйтай холбоотой онолууд			2	8	
	<b>Нийт</b>	<b>3</b>	<b>80</b>	<b>16</b>	<b>64</b>	
<b>Модуль II</b>						
10.	Эмнэлзүйн харилцаа, харилцааны ур чадвар			4	4	4
11.	Эмнэлзүйн харилцааны хэлбэрүүд, тэдгээрийн эерэг ба сөрөг талууд, сөрөг харилцаанаас урьдчилан сэргийлэх нь			4	8	4
12.	Сэтгэцийн эрүүл мэндийн эмнэлзүйн харилцааны онцлог			2	4	4
13.	Эмнэлзүйн харилцааны аюулгүй орчин			2	4	8
14.	Эмнэлгийн ажилтнаас хамааралтай сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал, эмгэгээс урьдчилан сэргийлэх нь			2	4	
15.	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламжийг олон нийтэд таниулах үйл ажиллагаанд сувилагчийн оролцоо			2		
16.	Олон талт мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаа, харилцааны онцлог				4	
17.	Эмнэлзүйн харилцаанд оролцогч талуудын сэтгэл зүй, зан үйлийн үндэс				4	8
18.	Үйлчлүүлэгчийн хэрэгцээнд тулгуурласан харилцааг удирдах арга				4	
19.	Сувилагч өөрийн сэтгэл хөдлөлөө мэдрэх, хянах, удирдах				8	
20.	Эмчлүүлэгчийн аюулгүй орчин бүрдүүлэлт, эмнэлгийн ажилчдын өөрсдийн аюулгүй байдал				8	
21.	Олон соёлт үйлчлүүлэгчийн итгэл үнэмшилд тулгуурлан харилцах				4	
22.	Эмнэлгийн мэргэжилтнээс шалтгаант өвчнүүдийн тухай				4	
23.	Эмнэлгийн мэргэжилтнээс шалтгаант сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал үүсэх шалтгаан, урьдчилан сэргийлэлт				4	4
	<b>Нийт</b>	<b>4</b>	<b>124</b>	<b>16</b>	<b>64</b>	<b>36</b>
<b>Модуль III</b>						
24.	Сэтгэцийн эмгэгтэй үйлчлүүлэгчийг үнэлэх нь			1	4	8
25.	Сэтгэцийн эмгэгтэй үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, эрсдлийн үнэлгээ			1	4	8
26.	Сэтгэцийн эмгэгийн оношлогооны тухай			1	4	8
27.	Сэтгэцийн эмгэгийн оношилгоонд сувилагчийн оролцоо			1	4	8
28.	Сэтгэц нөлөөт эмийн тухай ойлголт, эмчилгээний менежмент			1	4	8
29.	Эмийн бус эмчилгээнд сувилагчийн оролцоо			1	4	8
30.	Сэтгэцийн нөлөөт эмийн эмчилгээний зохицолын тухай ойлголт			1	4	4
31.	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд сувилагчийн үүрэг			1	4	

32.	Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагчийн зайлшгүй эзэмшвэл зохих ур чадварууд, онцлог			1	4	4
33.	Нотолгоонд суурилсан тусламж үйлчилгээг практикт хэрэглэх нь			1	4	4
34.	Нотолгоонд суурилсан сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламжийн орчин үеийн чиг хандлага			1	4	4
35.	Сэтгэцийн эрүүл мэндийн чанарыг үнэлэх модел, арга аргачлал			1	4	
36.	Сэтгэцийн эрүүл мэндийн чанарын тухай ерөнхий ойлголт			1	4	
37.	ДЭМБ-аас гаргасан сэтгэцийн эрүүл мэндийн тусламжийн чанарын тухай			1	4	
38.	Улс орны соёлд тохирохуйц хувь хүнд тохируулсан тусламж үйлчилгээ,			1	4	
39.	Сувилахуйн онолууд			1	4	
	<b>Нийт</b>	<b>5</b>	<b>144</b>	<b>16</b>	<b>64</b>	<b>64</b>
<b>Модуль IV</b>						
40.	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд оролцогч талууд, тэдгээрийн үүрэг оролцоо, ёс зүйн асуудлууд			2	4	4
41.	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд үйлчлүүлэгчийг татан оролцуулах, хамтран ажиллах хэлбэрүүд			2	4	8
42.	Сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийн тухай хууль, эрх зүйн асуудлууд, хэрэгжилт			2	4	8
43.	Сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хамгаалах, дэмжих тусламж үйлчилгээ			2	4	4
44.	Нөхөн сэргээх эмчилгээний тухай ерөнхий ойлголт, үндсэн зарчмууд, олон улсын туршлага			2	4	8
45.	Нөхөн сэргээх эмчилгээний хамрах хүрээ, хэлбэрүүд, тэдгээрийн онцлог			2	4	12
46.	Сэтгэцийн үйлчлүүлэгчийн эмнэлэг хамгааллын дэглэм			2	4	12
47.	Сэтгэц нийгмийн нөхөн сэргээх эмчилгээний ач холбогдол, эмчилгээний үр дүнг тооцох аргууд			2	4	8
	<b>Нийт</b>	<b>4</b>	<b>112</b>	<b>16</b>	<b>32</b>	<b>64</b>
<b>Модуль V</b>						
48.	Сэтгэцийн хямралын үеийн үнэлгээ, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх			2	16	16
49.	Сэтгэлийн гэмтлийн дараах хариу урвалын үеийн тусламж үйлчилгээ			3	16	16
50.	Сэтгэцийн эрүүл мэндийн донтолт судлалын асуудлууд (архи, тамхи, мансууруулах бодис, дэлгэцийн донтолт)			3	16	
51.	Сэтгэцийн хурц байдалтай үйлчлүүлэгчийн тухайн үеийн сэтгэцийн байдлыг үнэлэх, хямралын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх			3	16	12
52.	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрсдэлийг үнэлэх менежмент			3	12	
53.	Аюулгүй тасаг аргачлал, эмнэлзүйн аюулгүй орчныг бүрдүүлэх			2	8	8
54.	Зонхилон тохиолдох эмгэгтэй хүнийг хийж үнэлгээ өгч, илэрсэн шинжүүд дээр хэлэлцэн, багаар				12	12

	ажиллах					
55.	Эмнэлгийн тасгуудад эрсдэлийг бууруулах зорилгоор амиа хорлох, хурц догшрол, хоолноос татгалзах, кататоник хөшилтийн үеийн түрэмгийллийг намжаах /хурц тасгуудад/					12
56.	Хүчирхийлэл, түрэмгийллийн үйлчлүүлэгчдэд сэтгэлзүйн байдлыг үнэлэх, сэтгэлзүйн байдлыг үнэлэн, хямралын төлөвлөгөө ашиглах яаралтай тусламжийг үзүүлэх /яаралтай тусламжийн тасагт/					12
57.	Дистрессийн үеийн сэтгэлзүйн байдлыг үнэлэх, сэтгэлзүйн байдлыг үнэлэн, хямралын төлөвлөгөө ашиглах яаралтай тусламжийг үзүүлэх					12
58.	Амиа хорлох эмгэгийн үеийн сэтгэлзүйн байдлыг үнэлэх, сэтгэлзүйн байдлыг үнэлэн, хямралын төлөвлөгөө ашиглах яаралтай тусламжийг үзүүлэх					12
59.	Бусад сэтгэцийн эмгэгийн сэтгэлзүйн байдлыг үнэлэх, сэтгэлзүйн байдлыг үнэлэн, хямралын төлөвлөгөө ашиглан яаралтай тусламжийг үзүүлэх					12
	<b>Нийт</b>	<b>8</b>	<b>240</b>	<b>16</b>	<b>96</b>	<b>124</b>
<b>Сургалтын нийт кредит</b>		<b>24</b>		<b>5</b>	<b>10</b>	<b>9</b>
<b>Нийт цаг</b>			<b>688</b>	<b>80</b>	<b>320</b>	<b>288</b>
<b>Сонгон судлах хичээл</b>						
<b>Сэтгэл судлал (1 кр)</b>						
60.	Сэтгэл судлал бол шинжлэх ухаан болох нь			2	4	
	Танин мэдэхүйн процесс			2	4	
	Бие хүний сэтгэлзүй			2	4	
	Зөвлөгөө өгөх арга зүй			2	4	
<b>Бүгд</b>		<b>1</b>	<b>24</b>	<b>8</b>	<b>16</b>	<b>-</b>
<b>Сэтгэцийн өвөрмөц эмгэгүүд (1 кр)</b>						
61.	ДОХ эмгэгийн үеийн сэтгэл зүйн асуудлууд			2	4	
	COVID үеийн сэтгэл зүйн асуудлууд			2	4	
	Гамшигийн үеийн сэтгэл зүйн асуудлууд			2	4	
	Хавдартай хүний үеийн сэтгэл зүйн асуудлууд			2	4	
<b>Бүгд</b>		<b>1</b>	<b>24</b>	<b>8</b>	<b>16</b>	<b>-</b>
<b>Мэдрэл судлал (1 кр)</b>						
62.	Архинд донтолтын мэдрэлийн хам шинж			2	4	
	Невроз ба биеших эмгэг			2	4	
	Бага насны хүүхдэд тохиолдох мэдрэлийн эмгэг			2	4	
	Мэдрэлийн тогтолцооны хөгжлийн гажиг			2	4	
<b>Бүгд</b>		<b>1</b>	<b>24</b>	<b>8</b>	<b>16</b>	<b>-</b>
<b>Судалгааны арга (1 кр)</b>						
63.	Эпидмиологи			2	4	
	Дескриптив судалгааны аргууд			2	4	
	Аналитик судалгааны аргууд			2	4	
	Мета-анализ судалгаа			2	4	
<b>Бүгд</b>		<b>1</b>	<b>24</b>	<b>8</b>	<b>16</b>	<b>-</b>
<b>Англи хэл (1 кр)</b>						
64.	Charter 1. Meeting colleagues				8	
	Charter 2. Nursing assessment				8	
	Charter 3. The hospital team				16	
<b>Бүгд</b>		<b>1</b>	<b>24</b>	<b>-</b>	<b>32</b>	<b>-</b>

<b>Халдвар хамаагаалал (1 кр)</b>						
65.	Эмнэлгийн тусламжтай холбоотой халдваруудын тухай ойлголт, халдварт өртөх эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх нь			2	4	
	Халдварт өвчний урьдчилан сэргийлэлт, хяналт			2	4	
	Хог хаягдлын менежмент /COVID хяналт/			2	4	
	ЭТҮХХ-ын тандалт, халдвар хяналт, дэгдэлтийн үеийн арга хэмжээ			2	4	
<b>Бүгд</b>		<b>1</b>	<b>24</b>	<b>8</b>	<b>16</b>	<b>-</b>
<b>Нийт</b>		<b>6</b>	<b>152</b>	<b>40</b>	<b>112</b>	
<b>Мэргэшүүлэх хичээлийн тойролт</b>						
1	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн	I - V тасаг				
2	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн	V - XI тасаг				
3	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн	Хүүхдийн тасаг				
4	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн	Нөхөн сэргээх тасаг				

- Модуль тус бүр явцын үнэлгээ 5 удаа
- Тайлан хамгаалалт 2 удаа
- Төгсөлтийн шалгалт Онол дадлага
- Сонгон судлах 1 кр хичээлийг сонгон суралцана.



**Эрүүл Мэндийн Яамны дэргэдэх  
Сувилахуйн мэргэжлийн салбар зөвлөлийн  
хурлын протокол № 15**

2021 оны 12 сарын 16

**Хуралд оролцсон:** салбар зөвлөлийн дарга Г.Хулан, гишүүд Д.Солонго, В.Даваахүү, Г.Ганхуяг, Н.Хишигдэлгэр, П.Одонжил, Д.Нямсүрэн Б.Оюунбилэг нар цахимаар оролцов. Гишүүн Я.Энжаргал цахим шуудангаар саналаа ирүүлэв.

**Хэлэлцэх асуудлууд**

1. Элэгний цирозтой үйлчлүүлэгчийн сувилахуйн удирдамж
2. Зүрхний шигдээстэй үйлчлүүлэгчийн сувилахуйн удирдамж
3. **Момент төсөл болон төгсөлтийн дараах сургалт: сэтгэцийн сувилахуйн мэргэшсэн сувилагчийг бэлтгэх сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн танилцуулга**
4. Сувилахуйн багш нарын 3 чуулганы санхүүгийн тайлан

**Момент төслийн танилцуулга болон сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн  
мэргэшүүлэх сургалтын тухай**

**Б.Оюунбилэг:** Дараагийн хэлэлцэх асуудал нь Д.Энхтуяа, С.Дэлгэрмаа багш нар момент төслийн болон Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн 6 сарын хөтөлбөрийн танилцуулгыг хийнэ.

**Д.Энхтуяа:** Сайн байцаана уу. ЭМЯ-ны сувилахуйн мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүд та бүхэнд энэ оройн мэндийг хүргье. Монгол улсад сэтгэцийн эрүүл мэндийн төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөр боловсруулах момент төслийн танилцуулгыг хийе. Энэ хэсгийг танилцуулж байгаа учир нь АШУҮИС, Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв, Энэрэл ДС, Этүгэн ИС, Европийн 4 их сургууль оролцсон болно. Төслийн товч танилцуулгыг Дэлгэрмаа багш хийнэ.

**С.Дэлгэрмаа:** Та бүхэнд энэ оройн мэндийг хүргье. Манай төсөл нь 2018 онд зөвшөөрөгдсөн. Нээлт 2019 оны 1 сард хийсэн. АШУҮИС-тай хамтын гэрээг 2019 оны 7 сард хийсэн. 2021 оны 7 сард эхний санхүүжилт болох 178975 евро орж ирсэн. Төгсөлтийн дараах сэтгэцийн сургалтыг сайжруулах зорилгоор урт богино хугацааны 2 зорилт тавин ажилласан. 1-рт Сэтгэцийн эрүүл мэндийн төгсөлтийн дараах сургалтыг 6 сар болгон хэрэгжүүлэх, 2-рт сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн хичээлийг заах багш нар чадавхижуулах байсан болно. 3-рт олон улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ гэсэн богино хугацааны зорилгуудыг тавьж ажилласан. Урт хугацааны зорилго нь сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн мэргэжлийн нэр хүнд

өссөнөөр Монгол улсад сувилагчаар элсэх оюутны тоо нэмэгдэх, сувилагчийн ажил мэргэжлийн сонголтыг өргөжүүлэх, үйлчлүүлэгчид хүрэх тусламж үйлчилгээг сайжруулах. Хөтөлбөрт хамрагдсан түнш байгууллагууд: Их Британи Эссекс Их Сургууль, Финландын Хэрэглээний Их Сургууль, Нидерландийн Үтрекийн их сургууль АШҮИС, Этүгэн, Энэрэл. Ажлын хүрээнд 5 багц өөрчлөлт хийсэн. 1.Сургалтын хэрэгцээг үнэлэн 15 удаагийн хэлэлцүүлгээр төгсөлтийн дараах сэтгэцийн сувилахуйн хөтөлбөрийг боловсруулсан. Багш нарын заах ур чадвыг сайжруулахын тулд заах арга байрилд нэвтрүүлж буй инноваци-удиртгал хичээл, асуудалд суурилсан сурган заах арга зүй, заах арга барилд нэвтрүүлж буй инновац-2 хичээлүүд боловсруулан туршилтын ангид хэрэгжүүлсэн. Туршилтын анги нь 32 цагийн лекц, 8 цагийн семинараар 7 модул хичээл сургалт явуулсан. Чанарын баталгаажилтыг Туркукийн сургуулийн стандарт асуумжаар авч 0-5 оноогоор үнэлснээс дундаж оноо 4-өөс дээш байсан ба оролцогчдын саналд ковидын үеэр сургалтанд сурах нь амаргүй байлаа гэснээр нийт сургалын үр дүн сайн байсныг илтгэж байна.

**Д.Энхтуяа:** Сувилахуйн төгсөлтийн дараах сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн мэргэшүүлэх сургалын төлөвлөгөө, хөтөлбөрийн танилцуулгыг хийе. Хөтөлбөрийг өмнө хүргүүлсэн тул товч танилцуулгыг хийхийг хүсэж байна. Төслийн хүрээнд сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн мэргэшүүлэх 6 сарын хөтөлбөрөөр туршилт сургалтыг зохион байгуулсан. Эрүүл мэндийн хөгжлийн төв СЭМҮТ дээр 4 сарын сургалтын хөтөлбөр хэрэгжиж байгаа ба Монгол улсын дээд боловсролын тухай хууль, эрүүл мэндийн тухай, эмнэлгийн тусламжийн тухай хуулинд үндэслэдэг. Харин бид 6 сарын сургалтын хөтөлбөрийг эдгээр хууль, журмыг үндэслэн шинэчилсэн. 2021 онд индекс өөрчлөгдөн батлагдсан ба сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуй буюу олон улсын нэршилээрээ өөрчлөгдсөн. Мөн энэ хөтөлбөр нь БШУЯ-ны сайдын А/174, А/370, ЭМЯ-ны сайдын А/337 тоот гэсэн тушаалуудын хүрээнд явагдсан. АШҮҮИС-ийн төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах журам А/187, суралцагчийг үнэлэх журам А/144, цахим сургалт эрхэлэх журам А/118 тушаалуудыг үндэслэсэн. Монгол улсад сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн мэргэшлийн нэршил нь 4 удаа нэрээ өөрчилсэн ба олон улсын нэршлээр сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуй гэж нэрлэгдэж байгаа. Монгол улсад 3 сар 4 сар гэсэн 2 хөтөлбөр хэрэгжиж байна. Мөн сургалтын орчинг сайжруулахын тулд Сувилахуйн сургууль, СЭМҮТ-д хөрөнгө оруулалт хийгдсэн. Учир нь энд дадлага сургалт явагдаж байгаа. Хөтөлбөрийн туршилтаар нийт 17 төгсөгч төгссөн. Хөтөлбөрийн шинэчлэл хийх



үндэслэл нь судалгааны үр дүн, нийгмийн хэрэгцээ шаардлага, төрийн захирагааны төв байгууллагын тушаал, олон улсын чиг хандлагад ойртуулах, зайхуйгаас суралцахууд шилжих шилжилт, үр дүнд суурилсан сургахуй, суралцахууд үндэслэх зэрэг байлаа. 6 сараар суралцах сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулсан. АШУҮИС-ийн эрдмийн зөвлөлөөс баталсан. Сургалцагч нарт хөтөлбөрөө нарийвчлалтай танилцуулсан. 3 Тушаал дээр үндэслэн хөтөлбөр маань гарсан ба англи, монгол хэл дээр хэвлэгдэн гарсан ба та бүхэнд илгээсэн байгаа. Өмнөх стандартад байсан зүйлсийг мөн тусгасан. Мөн хөтөлбөрт алсан хараа буюу 6 сарын сургалтаар ямар мэргэжилтэн бэлтгэх гэж байгааг оруулж өгсөн. 10 чадамжтай төгсөх ба Канмедээс гаргасан 7 чадамжийг тодорхойлж өгсөн. Зорилтыг тодорхойлохдоо агуулга, хамрах хүрээ, сургалт удирдах багшид тавигдах шаардлага зэргийг оруулсан. Энэ бол өмнө байгаагүй. Хүрэх үр дүнг мэдлэг, ур чадвар, чадамж хэмээн тодорхойлсон. Сургалтын төлөвлөгөөнд заавал судлах хичээл, сонгон судлах, мэргэшүүлэх гэсэн томъёололоор оруулсан. Өмнө нь сонгон судлах хичээл байгаагүй. Нийт агуулга 12 кр-ээр нэмэгдсэн бөгөөд одоо 24 кр багтаамжтай болсон. Дөрөвдүгээрт өмнөх сургалт зөвхөн 12 кр байсан бөгөөд бид модульд хувааснаар сургалт илүү цэгцтэй, зохион байгуулалттай болсон. Модуль тус бүр зорилттой, ямар аргаар заах, ямар үнэлгээ хийх, ашиглах ном зүй, дадлагын тойролтын хуваарь, гардан үйлдэлийн жагсаалтыг гаргаж өгсөн. Тав дугаарт сургалтын арга зүйд лекц, семинар, дадлага, бие даалт, зайлшгүй суралцах бие даалтын сэдвүүд гэсэн байдлаар хуваасан. Зургаа дугаарт суралцагчийн үнэлгээнд явцын үнэлгээ, мэдлэгийн үнэлгээ, ур чадварын үнэлгээ, бие даалтын үнэлгээг зааж өгсөн. Долоод нь ашиглах ном сурах бичгүүдийг тодорхой болгосон. 3 сарын сургалтын хөтөлбөрөөс ялгаатай нь хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг хэрхэн хийхийг оруулж өгсөн. Ингэхдээ сэтгэл ханамжийн үнэлгээ, явцын үнэлгээ, гүйцэтгэлийн үнэлгээ, үр нөлөөний үнэлгээ, хөтөлбөрийн санхүүгийн байдлын шинжилгээ хэмээн ялган оруулж эдгээр нь хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг хангана хэмээн үзсэн. Ес дүгээрт удирдлагын мэдээллийн систем байсан. Арав дугаарт харилцаа хамтын ажиллагаанд гадаад дотоодын ижил төстэй сургуулиудтай харьцуулах боломжтой байх, төр хувийн хэвшлийн их дээд сургууль болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, ажил олгогчтой харилцан үр дүнтэй хамтран ажиллахыг чухалчлан оруулсан. Ерөнхийдөө бол 6 сарын сургалт маань өмнө нь 3 сар, СЭМҮТ 4 сарын сургалт явуулж байсан нь хоорондоо харилцан адилгүй мэдлэг олгож байна гэж судалгааны үр дүнгээр гарсан тул Монгол улсын хэмжээнд

хэрэгжүүлэх Сэтгэцийн эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг баталж хөтөлбөр хэрэгжүүлэх зөвшөөрлийг олгож өгнө үү хэмээн хүсэж байна. Баярлалаа.

**Б.Оюунбилэг:** Гишүүдээс асуулт байна уу

**Л.Хишигдэлгэр:** материалыг үзэж танилцлаа. 1-рт Та бүхний хийсэн судалгаанаас харахад сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн сургалтыг явуулахад орчин болон ашиглах сурах бичиг хангалтгүй гэж гарсан байна. Энэхүү бэрхшээлээ хэрхэн, яаж давж гарсан бэ? 2-рт 6 сарын сургалт чинь өмнөх 3 сарын сургалтын агуулгыг сайжруулсан юм уу? Эсвэл агуулга нь багтахгүй байсан тул 6 сар болгосон юм уу? 3-рт өндөр хөгжилтэй орнуудад бааз хангалттай байдаг бол манайд ганцхан СЭМҮТ байгаа. Нэг эмнэлэг дээр 6 сар байрлах юм уу? Дадлагын бааз эмнэлгээ бэлдсэн юм уу?

**Д.Энхтуяа:** Төслийн хугацаанд 6 сарын сургалтыг явуулахдаа туршилтын хугацаанд бид гадагшаа явж сургалтанд суух боломжтой байсан боловч Ковидын нөхцөл байдлын улмаас явж чадаагүй. Мөн сургалт маань цахимаар болж байсан нь цахим сургалтыг хэрхэн зохион байгуулах вэ гэдэг бэрхшээлүүдтэй тулгарсан ч сургалт амжилттай явагдсан. Яг дадлага хийх хугацаа нь туршилтын үеэр бага байсан. Учир нь Ковидтай байлаа. Мөн оролцогчид маань гадагшаа явах байсан чадсангүй. Олон улсад 1 жилээр бэлддэг, манайд 3 сар байсан. Манайд 27 мэргэшүүлэх сургалтууд бүгд 3 сар байгаа. Олон улсын чиг хандлагад, түвшинд хүрэхгүй байгаа тул Монгол улсын хэмжээнд 6 сараар бэлтгэх нь одоогийн нөхцөл байдалд зүйтэй гэж үзэж байна. Сургалтын бааз эмнэлгүүдийн хувьд АШУҮИС, СЭМҮТ гэсэн 2 тусдаа байгууллагууд бэлдэж байна. Цаашид сувилахуйн сургалтыг Монгол улсад онолын академик байгууллагууд хийдэг, дадлагаа эмнэлэг дээр хийдэг болоход Сувилахуйн мэргэжлийн салбар зөвлөл дэмжиж өгөхийг хүсэж байна. Эмчийн сургалтууд сайн явж байгаа ч сувилагч нарын маань сургалт хангалтгүй байна. Хөтөлбөрт хамрагдсан сургуулиуд болон СЭМҮТ-д хөрөнгө оруулалт хийгдсэн. Жилдээ 15-20 орчим мэргэжилтэнг төгсгөх тул бааз эмнэлэг маань болно гэж үзэж байна. С.Дэлгэрмаа багш нэмэлт хариулт өгнө үү.

**С.Дэлгэрмаа:** Энэ бэрхшээлийг хэрхэн давсан бэ гэвэл 6 сарын хугацаанд сургалт явуулж байхдаа бид онол болон семинарын зарим хичээлийг дэлхийн чиг хандлагаа дагаад онлайн аар явуулах боломжтой хэмээн үзэж байгаа. Орны дэргэдэх сургалтыг хуучин 3 сарын сургалт шигээ өвчтөний дэргэд хийлгэнэ. Агуулгын хувьд 3 сард багтахгүй байсан гэж үзэж болно. Учир нь бүхэл бүтэн сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуй гэдэг шинжлэх ухааныг 3 сард багтаах боломжгүй. Өмнөх эмнэлгийн

мэргэшүүлэх сургалтуудыг эмч багш нар явуулдаг байсан тул өвчин заагаад байна гэсэн. Бидний гол зорилго нь өвчин бүрийн хямралыг хэрхэн давах уу, эмчийг ирэхээс өмнө өөрийгөө болон өвчтөнийг хэрхэн аюулгүй байлгах вэ, эрсдэлийг хэрхэн үнэлэх вэ зэргээр сургаж бэлтгэж байна. Өмнө сэтгэцийн сувилагч нарын авч байгаагүй шинэлэг мэдээллүүд, ялангуяа сэтгэцийн сувилагчийн үүргүүдийг тодорхой болгож байгаагаараа онцлог. Агуулгын хувьд нилээн цэгцтэй болгосон. Мөн эмнэлзүйн харилцаа гэдгийг бид өмнө ерөнхийд нь ярьж байсан боловч үнэхээр хангалтгүй зааж байсныг гадаад багш нарын тусламжтайгаар сайжруулсан. Бааз эмнэлгийн тухайд монголдоо ганц байгаа СЭМҮТ дээрээ хийнэ. Харин хоёрдугаар шатандаа наркалогийн төвүүдээр дамжихад боломжтой гэж үзэж байна. Даван туулахын дараагийн нэг зүйл нь багш нартайгаа хамтарсан сурах бичгүүдээ гаргах ажил байгаа. Энийг бол бид хийнэ. Сурах бичиг маань сувилахуйд түшиглэсэн байх болно. Энэ бүхнийг даван туулах боломжтой гэж үзэж байна.

**Л.Хишигдэлгэр:** хариултаа авч чадлаа. Баярлалаа.

**Д.Солонго:** Энхтуяа багшаас асуулт байна. Сувилагч нарт маань тэтгэлэг, цалин олгогдох уу. Резидент эмч нар цалинтай байгаа шүү дээ.

**Д.Энхтуяа:** Тиймээ резидент эмч нар бол цалинтай байгаа. Сувилагч нарын хувьд бол яригдаагүй байгаа. Бидний хувьд төгсөлтийн дараах сургалтынхаа үнэ цэнийг, чанарыг, төгсөгч нарынхаа ирээдүйг сайжруулах хэрэгтэй харагдаж байгаа. Иймийн тулд 6 сар болгох хэрэгтэй байна. Эрх зүйн үүднээсээ 1 жилийн сургалтанд цалин олгогдоно гэж байгаа гэсэн. Эмнэлгийн удирдлагууд 3 сарын сургалтанд сувилагч нарыгаа сургах тал дээр дэмжихгүй байна. Ер нь бол сувилагч нар маань эмч нартай нэг баг болон ажилладаг тул мэдлэг чадварыг нь ялгаагүй хөгжүүлэх шаардлагатай. 3 сарын сургалтаар мэдлэг чадварыг сайжруулна гэдэг хангалтгүй байна. Цаашдаа бид мэргэшүүлэх сургалтыг 6 сараас 1 жил болгох нь зүйтэй гэж үзэж байгаа. Үүний төлөө бид сайн ажиллах хэрэгтэй.

**Д.Нямсүрэн:** Төслийн хүрээнд тодорхой хугацаанд хөндлийн хянагчаар орж ажилласан. Энэ сургалт, төгслийг бол дэмжиж байна. Нийгэмд сувилагч нарын үүрэг оролцоо асар их нэмэгдэж байна. Иймээс хариуцлагатай чадвартай мэргэжилтэн бэлтгэх нь зүйтэй гэж үзэж байна.

**Д.Энхтуяа:** Суралцагчид бол үнэхээр сэтгэл хангалуун байсан. Мөн ажлын байран дээрээ хэрэглэх чадвартай болсон гэж байсан. Мөн багш нарын хувьд ч ялгаагүй 3 сарын сургалтаас илүү үр дүнтэй байсанд сэтгэл хангалуун байсан.

**Б.Оюунбилэг:** Дэмжиж байна.

**Д.Солонго:** Би хэдий сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйгаар мэргэшээгүй ч сувилагч хүн. Уг төслийн хүрээнд би нэг модулыг нь хариуцан ажилласан. Үнэхээр сурах зүйл ихтэй хөтөлбөр болсон. Бидний явуулж байгаа сургалтын ихэнхи нь өвчинд тулгуурласан. Уг хөтөлбөрийг харвал сувилагч нарын ажлын байранд яг тулгардаг асуудлыг зааж байсан. Европын холбооны багш нар бол бидэнд үнэхээр хэрэгтэй зүйл дээр тусалж ажилласан гэж үзэж байна. Энэ төслийг цаашид бусад мэргэшүүлэх сургалтууддаа түүчээ болон манлайлах хөтөлбөр хэмээн харж байгаагаа хэлмээр байна.

**Г.Хулан:** дэмжиж байна.

**В.Даваахүү:** Дэмжиж байна.

**Г.Ганхуяг:** Дэмжиж байна. Хэлэлцүүлж байгаа явдалд баярлалаа. Бид азтай ч гэх үү, манай багш нарт их том боломж олдсон. Энэхүү боломжийг бид сайн ашиглах хэрэгтэй. Миний хувьд дэмжиж байна. Та бүхэнд амжилт хүсье.

**Я.Энхжаргал:** Дэмжиж байна.

**Л.Хишигдэлгэр:** Дэмжиж байна.

**П.Одонжил:** дэмжиж байна.

**Шийдвэрлэсэн нь:** Монгол улсад Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн 6 сарын хугацаатай, 26 кр агуулгын багтаамжтай мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг гишүүд 100 хувийн саналаар дэмжив.

Протокол хөтөлсөн:


СМСЗ-ийн Нарийн бичиг *Б.Оюунбилэг* Б.Оюунбилэг

Хянасан:

СМСЗ-ийн дарга




Г.Хулан



МОНГОЛЫН  
СЭМЖЭГ  
МЭДИЙН  
ХАМГААГАХ  
ЯАМАГ

**СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН СУВИЛАГЧИЙН МЭРГЭШИЛ  
ЭЗЭМШҮҮЛЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР  
(MENTAL HEALTH NURSING)**

**УЛААНБААТАР**



МОНГОЛ  
УЛААНБААТАР  
СЭТГЭЦИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН  
СУВИЛАХУЙН  
МЭРГЭШҮҮЛЭХ  
СУРГАЛТЫН  
ХӨТӨЛБӨР

АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ  
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ, ЭРДМИЙН  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,

..... Н.ХҮРЭЛБААТАР

УХД0074 5845469

**СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН СУВИЛАХУЙН  
МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

УЛААНБААТАР  
2021

Энэхүү хөтөлбөрийг боловсруулахад Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яамны Сайдын 2014 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/174, 2014 оны 09 сарын 12 ны А/370, Монгол улсын Эрүүл Мэндийн Сайдын 2017 оны 09 сарын 01 ны А/337, Эрүүл Мэндийн Сайдын 2018 оны 10 сарын 19 ны А/427 дугаар тушаал, Эрүүл Мэндийн Сайдын 2021 оны 07 сарын 07-ны А/445 дугаар тушаал журмуудыг баримтлан боловсруулав.

## **ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ:**

Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн төлөөлөл:

1. АУС-ийн СЭМ-ийн тэнхмийн эрхлэгч, профессор З.Хишигсүрэн
2. Сувилахуйн сургуулийн багш, СУ-ны доктор, дэд профессор Д.Солонго
3. Сувилахуйн сургуулийн багш, УУ-ны доктор Ж.Мөнхханд
4. Сувилахуйн сургуулийн багш, АУ-ны магистр С.Дэлгэрмаа
5. Сувилахуйн сургуулийн багш, АУ ба ЭМУ-ны магистр Д.Байгалмаа
6. Сувилахуйн сургуулийн багш, СУ-ны магистр Л.Одгэрэл
7. МДИ-ийн ахлах арга зүйч, АУ-ны магистр Д.Энхтуяа

Этүгэн их сургуулийн төлөөлөл:

8. Этүгэн Их Сургуулийн Сувилахуйн сургуулийн захирал Б.Оюунцэцэг
9. Этүгэн их сургуулийн багш, СУ-ны магистр Б.Дүүрэнжаргал



Энэрэл Дээд Сургуулийн төлөөлөл:

10. Энэрэл дээд сургуулийн багш, СУ-ны магистр Н.Мөнгөнсор
11. Энэрэл дээд сургуулийн багш, Б.Өлзийжаргал


Эрүүл Мэндийн Байгууллагын төлөөлөл:

12. СЭМҮТ-ийн Сувилахуйн албаны дарга, БС-ын магистр О.Оюунтөгс
13. СЭМҮТ-ийн арга зүйч, СУ-ны магистр Д.Мөнгөнцэцэг
14. СЭМҮТ-ийн арга зүйч тэргүүлэх зэрэгтэй П. Бямбасүрэн

## **ХЯНАСАН:**

1. МДИ-ийн ахлах арга зүйч, АУ-ны магистр  Д.Энхтуяа
2. МДИ-ийн захирал, АУ-ны доктор, дэд профессор  Т.Баясгалан

## **ЗӨВШӨӨРСӨН:**

1. АШУҮИС-ийн Эмнэлзүй хариуцсан дэд захирал, Төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрийн дэд хорооны дарга  Д.Цэрэндавга



## **НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА**

### **1.1 Хөтөлбөрийн нэр**

Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуй - Mental health nursing

### **1.2 Мэргэшлийн индекс: S(s)09130014**

#### **1.2.2. Мэргэжлийн тодорхойлолт:**

Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн чиглэлээр мэргэшсэн, сэтгэцийн эмгэг, сэтгэцийн тулгамдсан асуудалтай хүмүүс, сэтгэлзүйн эмгэгүүдийн үед сэтгэцийн сувилахуйн өвөрмөц асаргаа сувилгааны үндсэн зарчим, ерөнхий ба төрөлжсөн тусламж, сувилахуйн үйл ажиллагааны дагуу хүний бие махбоди, сэтгэлзүй, нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, бие даасан, сэтгэл хангалуун амьдрахад нь тусламж үйлчилгээг үзүүлэх мэдлэг, чадвар, хандлага эзэмшсэн сувилагч мэргэжилтэнийг **СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН СУВИЛАГЧ** гэнэ.

#### **1.2.3 Эрх зүйн зохицуулалт:**

- Монгол Улсын Дээд боловсролын тухай хууль;
- Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хууль;
- Монгол Улсын Эмнэлгийн тусламжийн тухай хууль;
- БШУ-ны Сайдын 2014 оны А/174 тоот тушаал;
- БШУ-ны Сайдын 2014 оны А/370 дугаар тушаал;
- ЭМСайдын “Төгсөлтийн дараах үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” 2021 оны А/445 дугаар тушаал;
- ЭМС-ын “Журам шинэчлэн батлах тухай” 2017 оны А/337 дугаар тушаал;
- ЭМС-ын “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 2018 оны А/427 дугаар тушаал;
- АШУҮИС-ийн захирлын “Төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагааг зохицуулах тухай” 2019 оны 05 сарын 27 ны А/187 дугаар тушаалыг үндэслэн зохицуулагдана.

### **1.3 Хөтөлбөрийн үндэслэл**

ДЭМБ-ын 2001 оны тайланд дэлхий дахинаа 450 сая хүн сэтгэц, мэдрэл, мансууруулах бодист донтох эмгэгтэй, 4 хүн тутмын нэг нь сэтгэцийн тулгамдсан асуудалтай байна хэмээн дурьдаж байсан бол 2019 оны байдлаар хүн амын дунд зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгүүдээс сэтгэл гутралтай 264 сая, сэтгэлийн хөдөлгөөн цочирдлын 2 туйлт эмгэгтэй 45 сая, шизофрени өвчтэй 20 сая, тэнэгрэлтэй 50 сая хүн амьдарч байна гэж тогтоожээ. Түүнчлэн сэтгэл гутрал,

архинд донтох эмгэг, шизофрени, яльгүй зовлонт байдал зэрэг сэтгэцийн эмгэгүүд нь хөдөлмөрийн чадвар алдалтанд хүргэдэг 10 гол өвчний тоонд орсоор байна.

Дэлхий дахинаа сэтгэцийн эмгэгтэй хүмүүс, тэдний гэр бүлийнхэн нийгмийн ялгаварлан гадуурхалд өртөж, эмчилгээ тусламж шаардлагатай хүмүүсийн 76-85 % нь зохих тусламжаа авч чадахгүй идэвхитэй амьдрах, хөдөлмөрлөх насандаа хөдөлмөрийн чадвараа алдаж, амьдралын чанарт сөргөөр нөлөөлж эрт нас барах шалтгааны нэг болсоор байна.

Сэтгэцийн эрүүл мэнд нь эрүүл мэндийн салшгүй нэг хэсэг бөгөөд ДЭМБ-аас Сэтгэцийн эрүүл мэндийн цогц үйл ажиллагааны төлөвлөгөө 2012-2020"-г олон нийтийн нотолгоонд суурилсан, уялдаатай, сэтгэц-нийгмийн халамжийн үйлчилгээгээр хангах замаар бүх нийтийн эрүүл мэндийн үйл ажиллагаанд хамруулах зорилгоор боловсруулсан байна. Энэхүү төлөвлөгөөнд сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай холбоотой дараах 2 зорилтыг тусгасан байна. Үүнд.

1. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон эмчилгээ, оюуны эрүүл мэнд, амьжиргааг сайжруулах замаар нас баралтыг 2030 он гэхэд гуравны нэгээр бууруулах;
2. Архи, мансууруулах бодис хэрэглэх зэрэг хорт зуршлаас сэргийлэх, эмчлэх үйл ажиллагааг сайжруулах гэж заасан байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ нь хамтын, тасралтгүй явагдах үйл ажиллагаа юм. Иймд хүн амд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ нь бодлого боловсруулагчид, мэргэжлийн эмч, сувилагч, сэтгэлзүйч, туслах сувилагч, нөхөн сэргээх эмчилгээний ажилтан, сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжлийн холбоод, хамт олон, гэр бүл зэрэг өргөн хүрээний багийн хамтын ажиллагаа байдаг.

Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээ нь төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ учир мэргэшсэн баг ажиллах шаардлагатай байдаг.

ДЭМБ-ын судалгаагаар (2019) сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн 60-95% нь эрүүл мэндийн анхан шатны тусламжийн байгууллагад ханддаг учир сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагад сэтгэцийн эрүүл мэндийн сувилагч чухал үүрэгтэй болохыг онцлон дурьджээ. С.Y.Klein, ER Floves (2009) нарын судалгаагаар шаардлага хангахгүй хөтөлбөрөөр сургалтанд хамрагдсан, шинэ төгссөн сэтгэцийн эрүүл мэндийн сувилагч нарын 49% нь ажилдаа алдаа гаргадаг болохыг судлан тогтоосон бол M.T.Hickley, M Forbes

(2010) нар сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад сургалтын хөтөлбөрт агуулгын шинэчлэлт хийж байх нь чухал гэжээ.

Судлаач J.M. Dias, K.Ajani (2010) нар төгсөлтийн дараах сургалтын гол зорилго нь сувилахуйн гардан үйлдлийн ур чадвар, асуудлыг тодорхойлох, сэтгэн бодох, шийдвэр гаргах, багаар ажиллах ур чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн байх шаардлагатай гэсэн бол J.Montashami (2010) нар сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрт сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хууль эрх зүйн орчин, мэргэжлийн онцлог, үнэт зүйл, ялгаварлан гадуурхалт, муу нэрийн шошго зүүх үзэгдлээс урьдчилан сэргийлэх, зэрэг асуудлыг тусгасан цогц хөтөлбөр боловсруулах нь илүү ач холбогдолтой гэж үзсэн байна.

Монгол улсын хувьд 1934 оноос эхлэн Зөвлөлтийн мэргэжилтнүүдийн тусламжтайгаар сэтгэцийн эрүүл мэндийн сувилагч бэлтгэн эхэлсэн бөгөөд 2004 оныг хүртэл богино хугацаагаар сургалтыг зохион байгуулсаар ирсэн бөгөөд 2004-2016 онд сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн мэргэшлийн төгсөлтийн дараах сургалтыг 3 сарын хөтөлбөрөөр, 2019 оноос эхлэн 4 сарын хөтөлбөрөөр явуулж байна. СЭМҮТ-ийн статистик мэдээллээс үзвэл 2019 оны байдлаар СЭМҮТ-ийн амбулаторид 6461 хүн үйлчлүүлсэн, стационарт 7194 эмчлүүлэгч хэвтэн эмчлүүлсэн бөгөөд улсын хэмжээнд сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагч 172 ажилладаг байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагч бэлтгэх хөтөлбөрийн үнэлгээний хувьд 2010 онд ЭМЯ-наас “Нэгдмэл хөтөлбөр- Нэг стандарт” уриан дор сэтгэцийн эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөрт анх удаа үнэлгээ хийсэн байна (Г.Цэцэгдарь, З.Хишигсүрэн). Судлаач Л.Одгэрэл нарын (2020) онд улсын хэмжээнд сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагч нарын дунд хийсэн судалгаагаар судалгаанд хамрагдагсдын 32.6% нь сургалтын орчин хангалтгүй, 41.3% нь ном сурах бичгийн хүрэлцээ дунд зэрэг, 37% нь онол дадлагын хичээлийн уялдаа хангалтгүй гэсэн үр дүн гарсан байна.

Иймд орчин үеийн, олон улсын бодлого, зарчимд тулгуурласан, эмнэлэгт суурилсан тусламжаас нийгэм- олонд суурилсан тусламж руу, эмч, эмнэлгийн ажилтан төвтэй харилцаанаас эмчлүүлэгч төвтэй харилцаа руу, өвчинд суурилсан тусламжаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд суурилсан тусламж руу чиглэсэн,

нотолгоонд суурилсан тусламж үйлчилгээ үзүүлэх цогц чадамж бүхий мэргэшсэн сувилагч бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсруулах шаардлага тулгарч байна

## **ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО**

Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийн хэрэгцээнд нийцсэн сувилахуйн тусламж үзүүлэх өндөр мэдлэг, эмнэлзүйн ур чадвартай, мэргэжлийн ёс зүй, хандлага төлөвшсөн, цогц чадамж бүхий мэргэшсэн сувилагч бэлтгэхэд оршино.

### **2.1 Алсын хараа**

Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагч нь хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, сэтгэцийн эмгэгээс урьдчилан сэргийлэх, сувилахуйн тусламж үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэх мэдлэг, хандлага, ур чадвар, хүний эрхийг эрхэмлэн дээдэлдэг, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг баримталдаг, сувилахуйн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий мэргэжилтэн байна.

Энэхүү хөтөлбөрийг боловсруулахдаа Монгол Улсад мөрдөж байгаа хууль тогтоомжийн шаардлагыг биелүүлэх, ажил олгогч нарын хэрэгцээг хангахын зэрэгцээ олон улсын чиг хандлагад нийцсэн мэдлэг, чадвар, чадамжтай мэргэжилтэн бэлтгэх зорилтын хүрээнд дараах мэргэшлийн цогц чадамжийг эзэмшинэ. Үүнд

#### **1. Мэргэжилтэн байх**

- Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шатлал бүрт хөтлөгдөх бичиг баримтыг зохих журмын дагуу хөтлөх;
- Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагаанд багаар оролцох;
- Хүн амыг сэтгэцийн эмгэгээс урьдчилан сэргийлэх, сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтанд оролцох, сургалт удирдан явуулах;
- Үйлчлүүлэгч, эмчлүүлэгчийн нууцыг хадгалах;
- Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд ар гэр, асран хамгаалагчийг татан оролцуулах;
- Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд үйлчлүүлэгчийг татан оролцуулах;
- Хүн амд сэтгэцийн эмгэгийн үеийн төрөлжсөн сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлэх;;

- Эмчлүүлэгч, үйлчлүүлэгчийн биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг үнэлэх, ажиглах, асуумж авах, сорил авах, сувилахуйн тусламж үйлчилгээг шатлалын дагуу гүйцэтгэх
- Шаардлагатай үед сэтгэцийн эрүүл мэндийн яаралтай тусламж үзүүлэх;

## **2. Мэргэшсэн байх**

- Сэтгэцийн эрүүл мэндийн төрөлжсөн нарийн мэргэшлийн дагуу мэргэшсэн байх;
- Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр хамтран ажилладаг байгууллагуудад мэргэшлийн тусламж дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах;
- Мэргэшлийн ёс зүйг баримталдаг байх;
- Мэргэшлийн дагуу сэтгэцийн эмгэгийн онцлогт тохируулан эмчлүүлэгч, үйлчлүүлэгчид хувьчилсан тусламж үйлчилгээ үзүүлдэг байх;

## **3. Суралцагч байх**

- Мэргэшлийн чиглэлээр албан болон албан бус сургалтаар тасралтгүй суралцагч байх;
- Өөрийгөө хөгжүүлэх замаар бусдад тусламж дэмжлэг үзүүлдэг байх;
- Мэргэшлийн дагуу өөрийн орны болон олон улсын түвшний ололт амжилтаас суралцах;
- Багаар ажиллан бусдаас суралцах;

## **4. Харилцагч байх**

- Нийгмийн олон талт харилцаанд оролцогч, харилцагч байх;
- Үйлчлүүлэгч болон эмчлүүлэгч, ар гэр, асран хамгаалагч нартай зөв боловсон харилцах;
- Харилцаанд гадаад болон зохисгүй үг хэллэг хэрэглэхгүй байх;
- Эмчлүүлэгч, үйлчлүүлэгчийн сэтгэцийн байдалд тохируулан харилцах ур чадвартай байх;

## **5. Хамтрагч байх**

- Багаар хамтран ажиллах чадвартай байх;
- Салбар хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд санаачлагатай байх
- Хамтрагч, багийн гишүүний үүргээ хариуцлагатай биелүүлэх;
- Аливаа асуудалд хамтын шийдвэр гаргах;;

## **6. Нийгмийн эрүүл мэндийн зөвлөгч байх**

- Эрүүл мэндийн боловсрол олгох, сургалт зохион байгуулах

- Сэтгэцийн эмгэгээс урьдчилан сэргийлэх, стресс тайлах ур чадварт сургах сургалтыг явуулах;
- Эрүүл ахуй, эрүүл аж төрөх зан үйлд сургах талаар үйл ажиллагаа явуулах;

#### **7. Манлайлагч, зохион байгуулагч байх**

- Сувилахуй тусламж үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд манлайлан ажиллах;
- Байгууллагын үйл ажиллагаанд бусдыгаа манлайлах үүрэгтэй оролцдог байх;
- Үйл ажиллагааг зохион байгуулах чадвартай байх;

#### **2.2 Сургалтын зорилт**

1. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүтэц, хууль, эрхзүйн асуудлууд, хувь хүний хөгжил, өөрийгөө хөгжүүлэх үйл явц, стратеги дээр тулгуурлан, нийгмийн онол, үзэл баримтлал, эрүүл мэндийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх бүх түвшинд шийдвэр гаргахад сувилагчийн оролцоог нэмэгдүүлэх, манлайллыг бий болгох;
2. Сэтгэцийн сувилагчийн ажлын байр дээрх бэрхшээлийг даван туулах, харилцааны ур чадварыг хөгжүүлэх, сайжруулах, бие махбоди, сэтгэцийн эмгэгтэй хүмүүстэй ёс зүйн үүднээс нэр хүндийг эрхэмлэн, нотолгоонд суурилсан энэрэнгүй аюулгүй харилцаа, нийгмийн орчинд дасан зохицох чадвартай, хамтын ажиллагааг хангах;
3. Сувилагч нь сэтгэцийн эмгэгтэй хүний эмчилгээнд гэр бүлийг татан оролцуулан, гэр бүлд чиглэсэн олон нийтийн сувилахуйн тусламж үйлчилгээг бий болгох, дэмжих боломжийг эрэлхийлэх, нийгмийн эрүүл мэндийг дэмжих, сурталчлах, олон нийтийн хөгжилд сувилагчийн үүрэг ролийг нэмэгдүүлэх;
4. Сэтгэцийн эмгэгтэй үйлчлүүлэгчдэд хэрэглэгддэг сэтгэц нөлөөт эм бэлдмэлүүдийг зөв хэрэглэх, аюулгүй байдлыг хангах, эмийн бус эмчилгээнд үйлчлүүлэгчийг татан оролцуулах, шийдвэр гаргуулах, үйлчлүүлэгчийг эрхийг эрхэмлэн дээдлэх;
5. Сэтгэцийн зонхиолон тохиолдох эмгэгүүд, хүчирхийлэл, түрэмгийлэл бүхий нийгэмд болон өөртөө аюултай үйлдэл хийж болзошгүй эмгэгтэй үйлчлүүлэгчдэд яаралтай тусламж үзүүлж, эрэмбэлэн ангилал хийх, хяналтын картыг хөтлөх, үнэлгээ хийх чадвар эзэмшүүлэх, эрсдэлийг үнэлэх, хямралын төлөвлөгөө боловсруулан удирдах, асаргаа, сувилгааны талаар

зөвөлгөө өгөх чадвар эзэмшүүлж, сувилгааны гардан үйлдлийг стандартын дагуу зөв гүйцэтгэх чадвар эзэмшүүлэх;

## **2.2 Хамрах хүрээ**

**2.2.1 Сургалтын хугацаа:** 6 сар, 26 долоо хоног үргэлжилнэ.

**2.2.2 Сургалтын агуулгын багтаамж:** Нийт 26 багц цаг

**2.2.3 Элсэгчдийн боловсролын түвшин:**

Анагаах ухааны боловсрол олгох дотоод, гадаадын их дээд сургуулийг дүүргэсэн диплом болон бакалаврын боловсролтой эрүүл мэндийн салбарт 2-оос доошгүй жил ажилласан сувилагч мэргэжилтэн байна.

**2.2.4 Сургалт удирдах багшид тавигдах шаардлага:**

- Эмнэлзүйн мэргэшүүлэх сургалтыг эмнэлзүйн сургагч багш удирдах;
- Тухайн мэргэжлээрээ магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;
- Мэргэжлийн ахлах ба түүнээс дээш мэргэжлийн зэрэгтэй байх;
- Тухайн мэргэжлээрээ 8 ба түүнээс дээш жил ажилласан байх;
- Хүчин төгөлдөр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх;
- Сургалт эрхлэх байгууллагатай гэрээ байгуулсан байх; (тухайн байгууллагын үндсэн ажилтны хувьд хөдөлмөрийн гэрээ, гэрээт ажилтны хувьд сургалт удирдах гэрээ байгуулах)
- Зөвхөн нэг байгууллагад сургалт удирдах гэрээ байгуулах;

**2.2.5 Сургалт удирдан явуулах багш нар:**

Багш нар:

1. АУС-ийн СЭМ-ийн тэнхмийн эрхлэгч, профессор З.Хишигсүрэн
2. Сувилахуйн сургуулийн багш, АУ-ны магистр С.Дэлгэрмаа
3. Сувилахуйн сургуулийн багш, СУ-ны доктор, дэд профессор Д.Солонго
4. Сувилахуйн сургуулийн багш, УУ-ны доктор Ж.Мөнхханд
5. Сувилахуйн сургуулийн багш, СУ-ны магистр Л.Одгэрэл
6. Сувилахуйн сургуулийн багш, АУ, ЭМУ-ны магистр Д.Байгалмаа
7. МДИ-ийн ахлах арга зүйч, АУ-ны магистр Д.Энхтуяа
8. Этүгэн их сургуулийн Сувилахуйн сургуулийн захирал Б.Оюунцэцэг
9. Этүгэн их сургуулийн багш, СУ-ны магистр Б.Дүүрэнжаргал
10. Энэрэл дээд сургуулийн багш, СУ-ны магистр Н.Мөнгөнсор
11. Энэрэл дээд сургуулийн багш, Б.Өлзийжаргал
12. СЭМҮТ-ийн Сувилахуйн албаны дарга, БС-ын магистр О.Оюунтөгс



13. СЭМҮТ-ийн арга зүйч, СУ-ны магистр Д.Мөнгөнцэцэг
14. СЭМҮТ-ийн арга зүйч, Тэргүүлэх зэргийн сувилагч П. Бямбасүрэн
15. Энэрэл дээд сургуулийн багш, Тэргүүлэх зэргийн сувилагч С.Цэцэгмаа

Сонгон суралцах хичээлийг хөтлөн явуулах багш нар:

1. Сувилахуйн сургуулийн багш, АУ-ны доктор Р.Оргилмаа
2. Сувилахуйн сургуулийн багш, БС-ын магистр Э.Бат-Өлзий
3. Сувилахуйн сургуулийн багш, БС-ын магистр И.Нарантуяа
4. Сувилахуйн сургуулийн багш, БУ-ны магистр Б.Гантуяа
5. Сувилахуйн сургуулийн багш, ХШУ-ны магистр Ч.Оюунаа

#### **2.2.6 Элсэгчдэд тавигдах шаардлага**

Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн мэргэшүүлэх сургалтанд сувилахуйн мэргэжлийн диплом болон бакалаврын боловсролтой түүнээс дээш боловсролын зэрэгтэй, сувилагч мэргэжлээр 2 түүнээс дээш жил ажилласан туршлагатай, сувилах мэргэжлийн эрх бүхий сувилагчийг элсүүлнэ.

#### **2.2.7 Сургалтын залгамж холбоо**

А. Босоо тэнхлэгээр: Анатом, Физиологи, Эмгэг анатом, Эмгэг физиологи, Эм судлал, Сэтгэл судлал, Харилцааны ур чадвар, Нийгмийн эрүүл мэнд

Б. Хэвтээ тэнхлэгээр: Ерөнхий сувилахуй, Мэдрэлийн өвчний сувилахуй, Хүүхдийн сувилахуй, Дотрын сувилахуй, Өрхийн анагаах ухаан, Гэрийн сувилахуй

#### **2.2.8 Сургалтын нөхцөл**

Суралцагч нь сургалт явуулах гэрээт эмнэлгүүдийн тасаг нэгжид ажиллах, интерактив, асуудал шийдвэрлэх арга барилыг сурахад таатай орчин, хангалттай зай талбай, номын сан, видео, ухаалаг самбар, LCD төхөөрөмж ашиглах боломжтой сургалтын өрөө бүхий нөхцөл боломжоор хангагдсан байна. Мэргэжлийн үндсэн сурах бичиг, монографи, гарын авлага, мэргэжлийн сэтгүүл бүхий номын сантай байна. Цахим номын сангийн хөмрөг нь цахим ном, цахим сэтгүүл, эрдэм шинжилгээний бүтээл, цахим лекц, мультмедиа интерактив хичээлүүдээс бүрддэнэ.

#### **2.2.9 Хөтөлбөрийн төгсгөлд хүрэх үр дүн**

Сэтгэцийн эмгэгтэй хүнд уян хатан үзэл баримтлал, энэрэн нигүүлсэх, нөхөн сэргээх, нийгмийн оролцоог нэгтгэх, асуудлыг шийдвэрлэх, шийдвэрлэхэд өөрийгөө удирдан чиглүүлж, уялдаа холбоогоо харуулах, мэргэжлийн эсвэл түүнтэй адилтгах түвшний ажлуудыг төлөвлөх, хэрэгжүүлэхдээ бие даасан байдлыг бий болгох.

Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн судалгаа, дэвшилтэт технологийг ашиглах, шинэ таамаг дэвшүүлэх, нарийн төвөгтэй асуудлуудыг системтэйгээр, бүтээлч байдлаар шийдвэрлэх, нотолгоонд суурилсан дүгнэлт хийж, урьдчилан таамаглах, эрсдлийг боломж болгох нөхцөл байдалд шийдвэр гаргахад суралцах

#### **Зайлшгүй эзэмшвэл зохих мэдлэг**

- Сэтгэцийн эрүүл мэндийн бодлого боловсруулахад олон улсын болон үндэсний хэмжээн дэхь сувилагчийн оролцоо;
- Сэтгэцийн эрүүл мэндийн тухай үндэсний хэмжээний хууль эрх зүйн бодлого, тунхаг, баримт бичгүүд талаарх мэдлэг эзэмших;
- Үйлчлүүлэгчдэд эмчилгээний харилцааг бий болгох, эрүүл мэндийг удирдах талаар мэдэх;
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудал, тусламж үйлчилгээний соёлын мэдрэмж
- Үйлчлүүлэгч, тэдний гэр бүл, асран хамгаалагчдын боловсролд тохирсон заах, сургах олон төрлийн стратегийн талаархи мэдлэг эзэмших;
- Сувилахуйн гардан тусламж үйлчилгээний талаархи багийн арга барил дахь чадамж, сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн чадамжийн тухай ойлголт, чадамжид суурилсан ур чадвар, тусламж үйлчилгээний чанарын баталгаажилт, эрсдэл, хямралын талаарх ойлголт;
- Сэтгэцийн эмгэгийн талаарх мэдлэг, яаралтай тусламж, эмийн ба эмийн бус эмчилгээ, олон нийтийн, сайн дурын, хувийн болон өөртөө туслах бүлгийн үйлчилгээний талаарх мэдлэг;
- Мэргэжлээрээ насан туршийн боловсрол эзэмших, мэргэжлээ тасралтгүй хөгжүүлэх;

#### **Зайлшгүй эзэмшвэл зохих чадвар**

- Үйлчлүүлэгчдэд чиглэсэн зорилготой (анхаарал хандуулах, үйлчлүүлэгчийг татан оролцуулах) нотолгоонд суурилсан үнэлгээ, эмнэлзүйн үнэлгээ, сувилахуйн тусламжийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх үйл ажиллагааг олон талт нөхцөлд хийх;
- Эмнэлзүйн харилцааны ур чадварыг үр дүнтэй ашиглах нь өрөвдөх сэтгэлтэй, ялгаварлан гадуурхахгүй, нөхцөлд байдалд тохируулан мэдрэмтэйгээр тусламж үзүүлэх;
- Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд оролцдог бусад хүмүүстэй хамтран ажиллах, зохих ёс зүй, хууль эрх зүй, мэргэжлийн болон бодлогын

- хүрээнд үйлчлүүлэгч, гэр бүл, асран хамгаалагч, олон талт багийн гишүүдтэй хамтарч зөвөлгөө өгөх, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт явуулах;
- Сэтгэцийн эмгэгтэй үйлчлүүлэгчдийн биеийн байдалд үнэлгээ, оношлогоо, хэрэгжүүлэх, төлөвлөлт хийх чадварт манлайлан суралцах;

#### **Зайлшгүй эзэмшвэл зохих хандлага**

- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг баримтлан, харилцааны өндөр соёлтой байх;
- Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдал, ар гэрийнхний нийгэмд эзлэх байр суурийг үл харгалзан хүнлэг энэрэнгүй, чин сэтгэлээсээ хандаж сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлэх;
- Хамтран ажилладаг бусад мэргэжил нэгт нөхөд болон үйлчлүүлэгч, тэдний ар гэрийнхнийг ойлгодог байх;

#### **2.2.10 Хөтөлбөрийн зохион байгуулалт, хариуцах нэгж:**

- АШУҮИС-ийн хөтөлбөрийн хороо, Мэргэжил дээшлүүлэх институт нь нэгдсэн удирдлагаар хангана.
- Сэтгэцийн эрүүл мэндийн төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалт нь үндсэн 5 модулиар явагдах ба лекцийн хичээл нь танхимын болон цахим хэлбэрээр, семинарын хичээл танхимаар, дадлагын хичээл нь хөтөлбөрийн дагуу тойролтоор явагдана.
- Сургалт явуулах, тойролт хийх хуваарийг сургалт хариуцан явуулах байгууллага батална.
- Семинар, лекц зохион байгуулах байгууллага нь АШУҮИС, Сувилахуйн сургууль, ЭТҮГЭН Их сургууль, Энэрэл Дээд сургууль байна.
- Дадлагын хичээл явуулах үндсэн байгууллага нь Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв байна.

### **ГУРАВ. СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Салбар: Сувилахуйн шинжлэх ухаан

Мэргэшлийн чиглэл: Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуй

Элсэгчдийн боловсролын түвшин: Диплом, бакалавр

Сургалтын төрөл: Мэргэшүүлэх

Сургалтын хэлбэр: Өдөр

Сургалтын хугацаа: 6 сар

Нийт багц цаг: 26 кредит

Удиртгал хичээл - 1 багц цаг

Мэргэшүүлэх хичээлийн онол - 5 багц цаг

Мэргэшүүлэх хичээлийн дадлага - 9 багц цаг

Семинар - 10 багц цаг

Сонгон судлах хичээл - 1 багц цаг

## ДӨРӨВ. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА

### 4.1 Хичээлийн товч тодорхойлолт

Сэтгэцийн эрүүл мэндийн сувилагч хүн амын сэтгэцийн эрүүл мэнд, нийгмийн дасан зохицох байдал алдагдсан хувь хүмүүс, сэтгэцийн эмгэгийн ойлголтууд, бэрхшээлийг хэрхэн даван туулах талаар итгэл үнэмшил, хүнлэг чанартайгаар сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр сувилахуйн тусламж үзүүлэх тухай мэдлэг, ур чадвар, хандлагыг эзэмшүүлэхэд чиглэгдсэн сургалт явуулна.

### 4.2 Мэргэшлийн хичээлийн агуулга

Энэхүү сургалт нь сэтгэцийн эрүүл мэндийн сувилагч нь сэтгэцийн хувьд эрүүл хүн амыг сэтгэцийн эмгэгээс урьдчилан сэргийлэх, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих тусламж үйлчилгээ үзүүлэх, сэтгэц нийгмийн тулгамдсан асуудалтай хүмүүст стрессийг даван туулах чадварт сургах, эрт оношлох, эмчлэх, өвчний хүндрэл, хөдөлмөрийн чадвар алдалт, дахилтаас сэргийлэхэд чиглэсэн тусламж үйлчилгээ, сэтгэцийн эмгэгтэй хүмүүст нийгэмд дасан зохицох, өдөр тутмын өөртөө үйлчлэх чадваруудыг сэргээх, дахилт, хүндрэл, нийгэмд аюултай үйлдэл хийхээс сэргийлэх, ялгаварлан гадуурхал, муу нэрийн шошго зүүх үзэгдлийг бууруулахад чиглэсэн мэргэшлийн сувилахуйн тусламж үзүүлэх тухай мэдлэг, ур чадвар, хандлагыг эзэмшүүлэхэд чиглэгдэнэ.

### 4.3 Лекцийн хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө

№	Хичээлийн сэдэв	Цаг
Модуль 1 Сэтгэцийн эрүүл мэндийн суурь ойлголт, түүхэн	Сэтгэцийн эрүүл мэндийн тухай орчин үеийн ойлголт, түүхэн хөгжил	2
	Сэтгэцийн эмгэг судлалын судлах зүйл ерөнхий ба тусгай сэтгэцийн эмгэг судлал Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүтэц, зохион байгуулалт	2
	Олон улсын түвшин дэх сэтгэцийн эрүүл мэндийн хууль эрх зүйн асуудлууд (хууль, бодлого, тунхаг, бодлогын баримт бичгүүд)	2

	Монгол улс дахь СЭМ-ийн тусламжийн хууль эрхзүйн асуудлууд (хууль, бодлого, тунхаг, бодлогын баримт бичгүүд)	2
	СЭМ-ийн бодлого боловсруулахад сувилагчийн оролцоо	2
	СЭМ-ийн бодлого болон үйлчилгээний чанарыг сайжруулах нь	2
	СЭМ-ийн сувилахуйн тусламж үйлчилгээнд оролцогч талуудын ёс зүйн асуудлын чиг хандлага, урьдчилан сэргийлэлт	2
	Сувилахуйн ёс зүй болон ёс зүйн код	2
	Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйтай холбоотой онолууд	2
Нийт цаг		16 цаг 1 кр
Модуль 2 Эмнэл зүйн харилцааны сувилахуйн	Эмнэлзүйн харилцаа, харилцааны ур чадвар	4
	Эмнэлзүйн харилцааны хэлбэрүүд, тэдгээрийн эерэг ба сөрөг талууд, сөрөг харилцаанаас урьдчилан сэргийлэх нь	4
	Сэтгэцийн эрүүл мэндийн эмнэлзүйн харилцааны онцлог	2
	Эмнэлзүйн харилцааны аюулгүй орчин	2
	Эмнэлгийн ажилтнаас хамааралтай сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал, эмгэгээс урьдчилан сэргийлэх нь	2
	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламжийг олон нийтэд таниулах үйл ажиллагаанд сувилагчийн оролцоо	2
Нийт цаг		16 цаг/ 1 кр
Модуль 3 Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээ	Сэтгэцийн эмгэгтэй үйлчлүүлэгчийг үнэлэх нь /нийгэм, сэтгэл зүй, бие махбодь /	1
	Сэтгэцийн эмгэгтэй үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, эрсдлийн үнэлгээ /орчин, үйлчлүүлэгч, тусламж үзүүлэгч/	1
	Сэтгэцийн эмгэгийн оношлогооны тухай /ажиглалт, асуумж, сорил, бодит үзлэг/	1
	Сэтгэцийн эмгэгийн оношилгоонд сувилагчийн оролцоо	1
	Сэтгэц нөлөөт эмийн тухай ойлголт, эмчилгээний менежмент	1
	Эмийн бус эмчилгээнд сувилагчийн оролцоо	1
	Сэтгэцийн нөлөөт эмийн эмчилгээний зохицолын тухай ойлголт	1
	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд сувилагчийн үүрэг	1
	Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагчийн зайлшгүй эзэмшвэл зохих ур чадварууд, онцлог	1
	Нотолгоонд суурилсан тусламж үйлчилгээг практикт хэрэглэх нь	1
	Нотолгоонд суурилсан сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламжийн орчин үеийн чиг хандлага	1
	Сэтгэцийн эрүүл мэндийн чанарыг үнэлэх модел, арга аргачлал	1

	Чанарын тухай ерөнхий ойлголт	1
	ДЭМБ-аас гаргасан сэтгэцийн эрүүл мэндийн тусламжийн чанарын тухай	1
	Улс орны соёлд тохирохуйц хувь хүнд тохируулсан тусламж үйлчилгээ,	1
	Сувилахуйн онолууд	1
<b>Нийт цаг</b>		<b>16 цаг/ 1кр</b>
<b>Модуль 4</b> Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд үйлчлүүлэгчийг татан оролцуулах, хамтран ажиллах арга	Сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн эрхийн тухай хууль, эрхзүйн асуудлууд, хэрэгжилт	2
	Сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хамгаалах, дэмжих тусламж үйлчилгээ	2
	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд оролцогч талууд, тэдгээрийн үүрэг оролцоо , ёс зүйн асуудлууд	2
	СЭМ-ийн тусламж үйлчилгээнд үйлчлүүлэгчийг татан оролцуулах, хамтран ажиллах хэлбэрүүд	2
	Нөхөн сэргээх эмчилгээний тухай ерөнхий ойлголт, үндсэн зарчмууд, олон улсын туршлага	2
	Нөхөн сэргээх эмчилгээний хамрах хүрээ, хэлбэрүүд, тэдгээрийн онцлог	2
	Сэтгэцийн үйлчлүүлэгчийн эмнэлэг хамгааллын дэглэм	2
	Сэтгэцийн үйлчлүүлэгчийн нөхөн сэргээх эмчилгээний ач холбогдол, эмчилгээний үр дүнг тооцох аргууд	2
	<b>Нийт цаг</b>	
<b>Модуль 5</b> Сэтгэцийн хямралын үеийн эмнэлзүйн менежмент, төлөвлөгөө болговсруулах, хэрэгжүүлэх	Эмнэлгийн орчин дахь сэтгэцийн хурц байдалтай үйлчлүүлэгчийг тухайн үеийн сэтгэцийн байдлыг үнэлэх, менежмент	2
	Сэтгэцийн гэмтлийн дараах хариу урвалын үеийн тусламж үйлчилгээ	3
	Сэтгэцийн эрүүл мэндийн донтолт судлалын асуудлууд (архи, тамхи, мансууруулах бодис, дэлгэцийн донтолт)	3
	Сэтгэцийн эмгэгтэй үйлчлүүлэгчийн тухайн үеийн сэтгэцийн байдлыг үнэлэх, хямралын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх	3
	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрсдэлийг үнэлэх менежмент	3
	Аюулгүй тасаг аргачлал, эмнэлзүйн аюулгүй орчныг бүрдүүлэх	2
<b>Нийт цаг</b>		<b>16 цаг/ 1кр</b>
<b>Онолын нийт цаг</b>		<b>80 цаг</b>
<b>Багц цаг</b>		<b>5 кр</b>

#### 4.4 Семинарын хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө

№	Хичээлийн сэдэв	Цаг
	Монгол улс дахь Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал	4
	Ерөнхий сэтгэцийн эмгэг судлал	4
	Тусгай сэтгэцийн эмгэг судлал	4
	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний онцлог, Сэтгэцийн эрүүл мэндийн төрөлжсөн тусламж үйлчилгээнд сувилагчийн гүйцэтгэх үүрэг	4
	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой зарим МУ-ын хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхэд сувилагчийн оролцоо /“Сэтгэцийн эрүүл мэндийн тухай”, “Архидан согтуурахтай тэмцэх тухай”, “Мансууруулах эм, сэтгэц нөлөөт бодисын эргэлтэнд хяналт тавих тухай”, “Тамхины хяналтын тухай” Монгол улсын хуулийг хэрэгжүүлэхэд сувилагчийн үүрэг, оролцоо	4
	“Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн үеийн сувилахуйн тусламж үйлчилгээний эмнэлзүйн удирдамж” “Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх тухай” МУ-ын ЭМС-ын тушаал	4
	Сэтгэцийн эрүүл мэндийн бодлого яагаад чухал вэ? Сэтгэцийн эрүүл мэндийн алсын хараа. Сэтгэцийн эрүүл мэндийн бодлого ба тусламж үйлчилгээний багц удирдамж	4
	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой Эрүүл мэндийн сайдын тушаал, журмыг хэрэгжүүлэхэд сувилагчийн оролцоо: “Эмнэлгийн яаралтай тусламжид үйлчлүүлэгчийг эрэмбэлэх заавар”, “Өвчний түүхийн хавсралт сувилгааны маягыг хөтлөх заавар”	4
	Сэтгэцийн эрүүл мэндийн бодлого боловсруулахад сувилагчийн оролцоо	8
	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар. Чанарыг сайжруулах нь яагаад чухал вэ? Чанар ба аюулгүй байдал	8
	Биоанагаахын ёс зүй ба сувилахуйн ёс зүйн ялгаа, ёс зүйн онол, харилцааны ёс зүй, үйлчлүүлэгчийн бие даасан байдал, эрх ашиг, шийдвэр гаргах эрхийг хүндэтгэх, муу үйлийг хориглох зарчим, судалгааны ёс зүй	8
	Сувилахуйн онолын талаарх ерөнхий ойлголт, Масловын Амьдралын хэрэгцээний эрэмбийн онол, Найтингейлийн философи, Хендерсон, /Betty Neuman/ Ньюман, Оремийн онолууд	8
Нийт цаг		64 цаг 2 кр
М о д у л	Эмнэлзүйн харилцааны тухай ерөнхий ойлголт, харилцааны соёл, ур чадвар, арга барил	4



	Олон талт мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаа, харилцааны онцлог	8
	Эмнэлзүйн харилцаанд оролцогч талуудын сэтгэл зүй, зан үйлийн үндэс	4
	Үйлчлүүлэгчийн хэрэгцээнд тулгуурласан харилцааг удирдах арга	4
	Сувилагч өөрийн сэтгэл хөдлөлөө мэдрэх, хянах, удирдах	8
	Харилцаанд оролцогч талуудын ятган үнэмшүүлэхийн үүрэг, ач холбогдол	4
	Эмнэлзүйн харилцааны хэлбэрүүд эерэг ба сөрөг харилцааны тухай	8
	Эмчлүүлэгчийн аюулгүй орчин бүрдүүлэлт Эмнэлгийн ажилчдын өөрсдийн аюулгүй байдал	8
	Олон соёлт үйлчлүүлэгчийн итгэл үнэмшилд тулгуурлан харилцах	4
	Эмч эмнэлгийн ажилтны нийтлэг гаргадаг алдаа, эмнэлзүйн харилцаан дахь сөрөг харилцаанаас урьдчилан сэргийлэх нь	4
	Эмнэлгийн мэргэжилтнээс шалтгаант эмгэгүүдийн тухай	4
	Эмнэлгийн мэргэжилтнээс шалтгаант сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал үүсэх шалтгаан, урьдчилан сэргийлэлт	4
	<b>Нийт цаг</b>	<b>64 цаг 2 кр</b>
Модуль 3 Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээ	Сэтгэцийн эмгэгтэй үйлчлүүлэгчийг үнэлэх нь /нийгэм, сэтгэл зүй, бие махбодь/	4
	Сэтгэцийн эмгэгтэй үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, эрсдлийн үнэлгээ /орчин, үйлчлүүлэгч, тусламж үзүүлэгч/	4
	Сэтгэцийн эмгэгийн оношлогооны тухай /ажиглалт, асуумж, сорил, бодит үзлэг/	4
	Сэтгэцийн эмгэгийн оношилгоонд сувилагчийн оролцоо	4
	Сэтгэц нөлөөт эмийн тухай ойлголт, эмчилгээний менежмент	4
	Эмийн бус эмчилгээнд сувилагчийн оролцоо	4
	Сэтгэцийн нөлөөт эмийн эмчилгээний зохицолын тухай ойлголт	4
	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд сувилагчийн үүрэг	4
	Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагчийн зайлшгүй эзэмшвэл зохих ур чадварууд, онцлог	4
	Нотолгоонд суурилсан тусламж үйлчилгээг практикт хэрэглэх нь	4
	Нотолгоонд суурилсан сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламжийн орчин үеийн чиг хандлага	4
	Сэтгэцийн эрүүл мэндийн чанарыг үнэлэх модел, арга аргачлал	4
	Чанарын тухай ерөнхий ойлголт	4
	ДЭМБ-аас гаргасан сэтгэцийн эрүүл мэндийн тусламжийн чанарын тухай	4

	Улс орны соёлд тохирохуйц хувь хүнд тохируулсан тусламж үйлчилгээ, Сувилахуйн онолууд	4 4
Нийт цаг		64 цаг/ 2 кр
Модуль 4 Үйлчлүүлэгчийн оролцоо, хамтын ажиллагаа, нөхөн сэргээх загвар	Сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хамгаалах, дэмжих тусламж үйлчилгээ	4
	Сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн эрхийн тухай хууль, эрхзүйн асуудлууд, хэрэгжилт	4
	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд оролцогч талууд, тэдгээрийн үүрэг оролцоо, ёс зүйн асуудлууд	4
	СЭМ-ийн тусламж үйлчилгээнд үйлчлүүлэгчийг татан оролцуулах, хамтран ажиллах хэлбэрүүд	4
	Нөхөн сэргээх эмчилгээний тухай ерөнхий ойлголт, үндсэн зарчмууд, олон улсын туршлага	4
	Нөхөн сэргээх эмчилгээний хамрах хүрээ, хэлбэрүүд, тэдгээрийн онцлог	4
	Сэтгэц нийгмийн нөхөн сэргээх эмчилгээний ач холбогдол, үр дүнг үнэлэх аргууд	4
	Сэтгэцийн үйлчлүүлэгчийн эмнэлэг хамгааллын дэглэм	4
Нийт цаг		32 цаг/ 1 кр
Модуль 5 Сэтгэцийн хямралын үеийн эмнэлзүйн менежмент, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх	Эмнэлгийн орчин дахь сэтгэцийн хурц байдалтай үйлчлүүлэгчийг тухайн үеийн сэтгэцийн байдлыг үнэлэх, менежмент	16
	Сэтгэлийн гэмтлийн дараах хариу урвалын үеийн тусламж үйлчилгээ	16
	Хурц тасагт яаралттай тусламж шаардагдах үйлчлүүлэгчдэд эмнэлгийн аюулгүй орчны эрсдлийг үнэлж, гардан тусламжийг стандартын дагуу гардан тусламж үзүүлсэн талаар багаар ажиллах	16
	Хурц тасагт байгаа үйлчлүүлэгчдэд эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдлийг бууруулах төлөвлөгөөг боловсруулж, түрэмгийллийг намжаах аргыг хэрэглэсэн талаар багаар ажиллаж, тайлагнах	16
	Хүчирхийлэл, түрэмгийллийн менежмент, намжаах аргуудыг судлан ярилцлага хийх, хямралын төлөвлөгөө SRABS аргаар боловсруулан хэлэлцэж, багаар ажиллах	12
	Тусгаарлах өрөөний аюулгүй орчныг бүрдүүлэх, анхаарах өрөөний хяналт хийж, үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд үнэлгээ өгч, багаар ажиллах	8
	Зонхилон тохиолдох хүүхэд, өсвөр насныхны сэтгэцийн эрүүл мэнд, харих насны сэтгэцийн эрүүл мэнд, бэлгийн эрүүл мэндийн асуудлуудтай хүмүүсийг хийж үнэлгээ өгч, илэрсэн шинжүүд дээр хэлэлцэн, багаар ажиллах	12

Нийт цаг	96 цаг/ 3 кр
Семинарын нийт цаг	320
Багц цаг	10 кр

#### 4.5 Дадлагын хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө

№	Хичээлийн сэдэв	Цаг
Модуль 2 Эмнэл зүйн харилцааны сувилахуйн менежмент	Эмнэлзүйн харилцаа, харилцааны ур чадвар	4
	Тасгийн доторхи аюулгүй орчин бүрдүүлэх	8
	Зан төлөв, түүний хурцдал, харилцааны стратеги	8
	Эмнэлзүйн харилцааны хэлбэрүүд, тэдгээрийн эерэг ба сөрөг талууд, сөрөг харилцаанаас урьдчилан сэргийлэх нь	4
	Сэтгэцийн эрүүл мэндийн эмнэлзүйн харилцааны онцлог	4
	Эмнэлгийн ажилтнаас хамааралтай сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал, эмгэгээс урьдчилан сэргийлэх нь	4
Нийт цаг		32 цаг 1 кр
Модуль 3 Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээ	Сэтгэцийн эмгэгтэй үйлчлүүлэгчийг үнэлэх нь /нийгэм, сэтгэл зүй, бие махбодь/	8
	Сэтгэцийн эмгэгтэй үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, эрсдлийн үнэлгээ /орчин, үйлчлүүлэгч, тусламж үзүүлэгч/	8
	Сэтгэцийн эмгэгийн оношлогооны тухай /ажиглалт, асуумж, сорил, бодит үзлэг/	8
	Сэтгэцийн эмгэгийн оношилгоонд сувилагчийн оролцоо	8
	Сэтгэц нөлөөт эмийн тухай ойлголт, эмчилгээний менежмент	8
	Эмийн бус эмчилгээнд сувилагчийн оролцоо	4
	Сэтгэцийн нөлөөт эмийн эмчилгээний зохицолын тухай ойлголт	4
	Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагчийн зайлшгүй эзэмшвэл зохих ур чадварууд, онцлог	4
	Нотолгоонд суурилсан тусламж үйлчилгээг практикт хэрэглэх нь	4
	Нотолгоонд суурилсан сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламжийн орчин үеийн чиг хандлага	4
Эмийн бус эмчилгээнд сувилагчийн ур чадвар	4	
Нийт цаг		64 цаг/ 2 кр
Модуль 4 Үйлчлүүлэгч ийн оролцоо, хамтын	Сэтгэцийн эмгэгтэй хүний эдлэх эрх, хэрэгжих боломж, хязгаарлагдмал байдал	4
	Монгол улс дахь сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийн хэрэгжилтийн өнөөгийн байдал	4
	Сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хамгаалах, дэмжих тусламж үйлчилгээ	4

	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд үйлчлүүлэгчийг татан оролцуулахтай холбоотой ёс зүйн хэм хэмжээ	4
	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламжид үйлчлүүлэгчийг татан оролцуулахад тулгарах бэрхшээл, түүнийг даван туулах	4
	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд үйлчлүүлэгчийг татан оролцуулах аргууд	4
	Үйлчлүүлэгчийг сонгох, сэтгэцийн эрүүл мэндийн тусламжид үйлчлүүлэгчийн оролцоо	4
	Нөхөн сэргээх эмчилгээний орчин үеийн чиг хандлага, олон улсын туршлага	8
	Сэтгэц нийгмийн нөхөн сэргээх эмчилгээ, түүний хэлбэрүүд	12
	Сэтгэцийн үйлчлүүлэгчийн эмнэлэг хамгааллын дэглэм	12
	Сэтгэцийн үйлчлүүлэгчийн нөхөн сэргээх эмчилгээний үр дүнг тооцох арга	4
Нийт цаг		64 цаг/ 2 кр
Модуль 5 Сэтгэцийн хямралын үеийн эмнэлзүйн менежмент, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх	Эмнэлгийн орчин дахь сэтгэцийн хурц байдалтай үйлчлүүлэгчийг тухайн үеийн сэтгэцийн байдлыг үнэлэх, менежмент	16
	Сэтгэлийн гэмтлийн дараах хариу урвалын үеийн тусламж үйлчилгээ	16
	Эмнэлгийн тасгуудад хүчирхийлэл, түрэмгийлэл, бусдад аюултай үйлдэл, оргох, сэтгэц хөдөлгөөний дошгирол, мансууруулах бодисын цочмог хордлого, хоолноос татгалзах, уналт, таталтын байдал эмгэгүүдийн үеийн яаралтай тусламжийн эрсдлийн үнэлгээ хийж, гардан тусламж үзүүлэх /хурц тасгуудад/	16
	Эмнэлгийн тасгуудад эрсдэлийг бууруулах зорилгоор амиа хорлох, хурц догшрол, хоолноос татгалзах, кататоник хөшилтийн үеийн түрэмгийллийг намжаах зорилгоор 180 тоот тушаалыг гардан хийж суралцах /хурц тасгуудад/	12
	Хүчирхийлэл, түрэмгийллийн үйлчлүүлэгчдэд сэтгэлзүйн байдлыг үнэлэх, сэтгэлзүйн байдлыг үнэлэн, хямралын төлөвлөгөө ашиглах яаралтай тусламжийг үзүүлэх /яаралтай тусламжийн тасагт/	12
	Дистрессийн үеийн сэтгэлзүйн байдлыг үнэлэх, сэтгэлзүйн байдлыг үнэлэн, хямралын төлөвлөгөө ашиглах яаралтай тусламжийг үзүүлэх	12
	Амиа хорлох эмгэгийн үеийн сэтгэлзүйн байдлыг үнэлэх, сэтгэлзүйн байдлыг үнэлэн, хямралын төлөвлөгөө ашиглах яаралтай тусламжийг үзүүлэх	12
	Бусад сэтгэцийн эмгэгийн сэтгэлзүйн байдлыг үнэлэх, сэтгэлзүйн байдлыг үнэлэн, хямралын төлөвлөгөө ашиглах яаралтай тусламжийг үзүүлэх	12
	Анхаарах өрөө, тусгаарлах өрөөнд аюулгүй орчинг бүрдүүлж, үйлчлүүлэгчийг хянах, тусламж үзүүлэх,	8

	ээлжинд хонож, сувилагч ээлж хүлээлцэх аргуудад дадлагажих /эмнэлгийн бүх тасгуудад/	
	Хүүхэд, өсвөр нас, харих насны сэтгэцийн эрүүл мэнд, бэлгийн эрүүл мэндийн асуудлуудтай хүмүүстэй ярилцлага хийх, хямралын төлөвлөгөө ашиглах яаралтай тусламжийг үзүүлэх	12
Нийт цаг		128 цаг 4 кр
Дадлагын нийт цаг		288
Багц цаг		9 кр

#### 4.6 Сонгон судлах хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө

№	ХИЧЭЭЛИЙН СЭДЭВ	ЦАГ
Сэтгэл судлал	Сэтгэл судлал бол шинжлэх ухаан болох нь	6
	Танин мэдэхүйн процесс	6
	Бие хүний сэтгэлзүй	6
	Зөвөлгөө өгөх арга зүй	6
Сэтгэцийн өвөрмөц эмгэгүүд	ДОХ эмгэгийн үеийн сэтгэл зүйн асуудлууд	6
	COVID үеийн сэтгэл зүйн асуудлууд	6
	Гамшигийн үеийн сэтгэл зүйн асуудлууд	6
	Хавдартай хүний үеийн сэтгэл зүйн асуудлууд	6
Мэдрэл судлал	Архинд донтолтын мэдрэлийн хам шинж	6
	Невроз ба биеших эмгэг	6
	Бага насны хүүхдэд тохиолдох мэдрэлийн эмгэг	6
	Мэдрэлийн тогтолцооны хөгжлийн гажиг	6
Судалгааны аргыг	Эпидмиологи	6
	Дескриптив судалгааны аргууд	6
	Аналитик судалгааны аргууд	6
	Мета-анализ судалгаа	6
Англи хэл	Charter 1. Meeting colleagues	8
	Charter 2. Nursing assessment	8
	Charter 3. The hospital team	16
Халдвар хамаагаалал	Эмнэлгийн тусламжтай холбоотой халдваруудын тухай ойлголт, халдварт өртөх эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх нь	6
	Халдварт өвчний урьдчилан сэргийлэлт, хяналт	6
	Хог хаягдлын менежмент /COVID хяналт/	6
	ЭТҮХХ-ын тандалт, халдвар хяналт, дэгдэлтийн үеийн арга хэмжээ	6
Нийт цаг		144

#### МОДУЛЬ 1. СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН СУУРЬ ОЙЛГОЛТ, ТҮҮХЭН ХӨГЖИЛ, ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮТЭЦ, ХУУЛЬ

### **Хичээлийн агуулга:**

Энэхүү модулийн хүрээнд Сэтгэцийн эрүүл мэндийн ерөнхий болон тусгай сэтгэцийн эмгэг судлалын өвөрмөц шинжүүд, түүхэн хөгжил, сэтгэцийн эрүүл мэндийн бодлого боловсруулахад олон улсад, үндэсний ба орон нутгийн хэмжээнд сувилагчийн оролцоо, олон улсын болон үндэсний хэмжээний сэтгэцийн эрүүл мэндийн тусламжийн хууль эрх зүйн асуудлууд, эрх зүйн зохицуулалт, ёс зүйн код, түүнтэй холбоотой судалгаа баримт, сувилахуйн тусламж үйлчилгээнд оролцогч талуудын ёс зүйн асуудлын чиг хандлага, урьдчилан сэргийлэлтийн талаар цогц мэдлэг, чадвар хандлагыг эзэмшинэ.

### **Заавал эзэмших мэдлэг**

- Сэтгэцийн эрүүл мэндийн тухай ойлголт
- Сэтгэцийн эрүүл мэндийн түүхэн хөгжил
- Ерөнхий ба тусгай сэтгэцийн эмгэг судлал
- Сэтгэцийн эрүүл мэндийн бодлого боловсруулахад олон улс болон үндэсний хэмжээнд сувилагчийн оролцоо
- Сэтгэцийн эрүүл мэндийн тухай үндэсний хэмжээний хууль эрх зүйн бодлого, тунхаг, баримт бичгүүд /Монгол улсад болон олон улсад мөрдөгдөж буй бүх эрх зүйн бодлого, хууль, акт/
- Сувилахуйн ёс зүй үзэл баримтлал, өмгөөлөл, хамтын ажиллагаа, бие даасан байдал /ёс суртахуун, ёс зүйн код ёс зүйн онол, зарчим/
- Эмнэлгийн мэргэжилтэний ёс зүйн хэм хэмжээтэй холбоотой хууль, тогтоомж, холбогдох бодлогын баримт бичиг
- Олон улсад болон Монгол улс дахь сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээний ёс зүйн асуудлууд, эрх зүйн зохицуулалт

### **Заавал эзэмших чадвар**

- Сэтгэцийн эрүүл мэндийн талаарх конвенци, тунхаг, тогтоол, хууль, 8журам, тушаал, шийдвэрийг таниулах сурталчилах
- Сэтгэцийн эрүүл мэндийн эмгэгийн эрүүл мэндийн талаарх конвенци, тунхаг, тогтоол, хууль, сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээг хүргэхэд эрсдлийг тооцох болон сэргийлэх чадвар эзэмших
- Ёс зүйн зарчмыг сувилахуйн ёс, сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн ёс зүйд хэрэглэх чадвартай болгох

- Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэх явцад ёс зүйн үнэ цэнийг тайлбарлан ойлгуулах
- Мэргэжлийнхээ болон үйлчлүүлэгч, нийгэм, хамт ажиллагсад, бусадтай болон эмнэл зүйн харилцааны ёс зүйг баримтлах арга зүйд сургах
- Ёс зүйн асуудал үүсэхээс сэргийлэх арга, асуудлыг шийдвэрлэх арга зүйд суралцах
- Тулгарч буй ёс зүйн асуудлын талаар судалгаа хийх, судалгаатай холбоотой мэдээллийг авч хэрэглэх арга зүйд сургах

### **Зайлшгүй эзэмших хандлага**

- Сэтгэцийн эмгэгтэй үйлчлүүлэгчийн эрхийг дээдлэх, хамгаалах
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай үйлчлүүлэгчид чин сэтгэлээсээ хандах
- Тусламж үйлчилгээ үзүүлэхдээ чин сэтгэлээсээ, хөнгөн шуурхай хүргэх
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай үйлчлүүлэгч, тэдний ар гэрийнхэнтэй харилцааны тохирох аргыг сонгож, эерэг харилцааг бий болгох
- Үйлчлүүлэгчид лчлүлахгч, тэдний ар гэрийнхэнтэй харилцааны тохирох аргыг сонгож, эерэг харилцааг бий болгох сургахарга зүйд сургах бодлого, хууль, акт/урьдчилан сэргийлэл
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай үйлчлүүлэгчтэй харилцахдаа тэдний байр сууринд өөрийгөө тавьж, асуудалд хандах

### **I МОДУЛИЙН ГАРДАН ҮЙЛДЛИЙН ЖАГСААЛТ**

№	Гүйцэтгэх үйлдэл	Сонссон ба харсан түвшин	Хийсэн түвшин	Чадсан түвшин	Гүйцэтгэх тоо
1	Сэтгэцийн эрүүл мэндийн тухай орчин үеийн ойлголт, түүхэн хөгжил		+		
2	Сэтгэцийн эмгэг судлалын судлах зүйл, салбар шинжлэх ухаан		+		
3	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүтэц, зохион байгуулалт			+	
4	Олон улсын түвшин дэх сэтгэцийн эрүүл мэндийн хууль эрх зүйн асуудлууд		+		
5	Монгол улс дахь СЭМ-ийн тусламжийн хууль эрхзүйн асуудлууд		+		
6	СЭМ-ийн бодлого боловсруулахад сувилагчийн оролцоо			+	+

7	СЭМ-ийн бодлого болон үйлчилгээний чанарыг сайжруулах нь			+	
8	СЭМ-ийн сувилахуйн тусламж үйлчилгээнд оролцогч талуудын ёс зүйн асуудлын чиг хандлага, урьдчилан сэргийлэлт		+		
9	Сувилахуйн ёс зүй болон ёс зүйн код		+		
10	Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйтай холбоотой онолууд		+		

### Сургалтын арга:

Лекц: Танхим, онлайн интерактив хэлбэрээр

Семинар: Асуудалд суурилсан сургалт, LBL, дүрд тоглох, багаар ажиллах, эмнэл зүйн ур чадварын хэлэлцүүлэг

### Үнэлгээ:

Хичээлийн ирц-10%

Хичээлийн явц-60% (багийн даалгавар-20%, хичээлийн идэвх, оролцоо-20%, Эссэ-20%) Хичээлийн төгсгөлд төгсөлтийн тест – 30%

### Хичээлийн төгсгөлд хүрэх үр дүн:

Мэдлэг – L3 түвшинд	
K1	Сэтгэцийн эрүүл мэндийн тухай ойлголттой болно
K2	Сэтгэцийн эрүүл мэндийн түүхэн хөгжлийн талаарх мэдлэгтэй болно
K3	Сэтгэцийн эмгэг судлалын судлах зүйл, салбар шинжлэх ухааны талаарх мэдлэг эзэмшинэ
K4	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүтэц, зохион байгуулалтын талаарх мэдлэгтэй болно
K5	Сэтгэцийн эрүүл мэндийн бодлого боловсруулахад сувилагчийн оролцоо олон улсад болон үндэсний хэмжээнд хэрхэн оролцдог талаарх мэдлэг хуримтлуулна.
K6	Сэтгэцийн эрүүл мэндийн тухай ОУ-ын хууль эрх зүйн бодлого, тунхаг, баримт бичгүүд
K7	Сэтгэцийн эрүүл мэндийн тухай үндэсний хэмжээний хууль эрх зүйн бодлого, тунхаг, баримт бичгүүд /Монгол улсад болон олон улсад мөрдөгдөж буй бүх эрх зүйн бодлого, хууль, акт/-ийн талаар мэдлэгтэй болно
K8	Сувилахуйн ёс зүйн мэдлэг эзэмшинэ
K9	Сувилахуйн ёс зүйн кодын талаарх ойлголттой болно
K10	Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээнд оролцогч талуудын ёс зүйн асуудлын чиг хандлага, урьдчилан сэргийлэлтийн тухай мэдлэг олгоно.
K11	Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйтай холбоотой онолын мэдлэгтэй болно.



<b>Чадвар – L3 түвшинд</b>	
S1	Сэтгэцийн эрүүл мэндийн талаарх конвенци, тунхаг, тогтоол, хууль, журам, тушаал, шийдвэрийг таниулах сурталчилах чадварт суралцана
S2	Сэтгэцийн эмгэгтэй хүний эрх зөрчигдөхөөс сэргийлэх, хамгаалах чадвар эзэмших
S3	Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээг хүргэхэд эрсдлийг тооцох болон сэргийлэх чадвар эзэмших
S4	Ёс зүйн зарчмыг сувилахуйн ёс болон Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн ёс зүйд хэрэглэх чадвартай болгох
S5	Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээнд ёс зүйн үнэ цэнийг тайлбарлах, ойлгуулах
S6	Мэргэжлийнхээ болон үйлчлүүлэгч, нийгэм, хамт ажиллагсад, бусадтай болон эмнэл зүйн харилцааны ёс зүйг баримтлах арга зүйд сургах
S7	Ёс зүйн асуудал үүсэхээс сэргийлэх арга, асуудлыг шийдвэрлэх арга зүйд суралцах
S8	Тулгарч буй ёс зүйн асуудлын талаар судалгаа хийх, судалгаатай холбоотой мэдээллийг авч хэрэглэх арга зүйд сургах
<b>Хандлага – L3 түвшинд</b>	
A1	Сэтгэцийн эмгэгтэй өвчтөний эрхийг дээдлэх, хамгаалах
A2	Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай үйлчлүүлэгчид тусламж үзүүлэхдээ чин сэтгэлээсээ, хөнгөн шуурхай үйлчилж, хандах
A3	Сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудалтай үйлчлүүлэгч, тэдний ар гэрийнхэнтэй харилцааны тохирох аргыг сонгож, эерэг харилцааг бий болгох
A4	Үйлчлүүлэгчид туслах гэж буйгаа мэдрүүлэх
A5	Аливаа асуудалд багаараа хамтран шийдвэрлэх
A6	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд оролцогч талуудын эрх, үүргийг мөрдөх
A7	Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай үйлчлүүлэгчтэй харилцахдаа тэдний байр сууринд өөрийгөө тавьж, асуудалд хандах

## **МОДУЛЬ 2: ЭМНЭЛ ЗҮЙН ХАРИЛЦААНЫ СУВИЛАХУЙН МЕНЕЖМЕНТ**

### **Хичээлийн агуулга:**

Эмнэлгийн мэргэжилтний харилцаа нь үйлчлүүлэгчийн сэтгэл зүйд нөлөөлж, амжилттай удирдан залах арга техник, үйл явц юм. Эмнэлгийн мэргэжилтний харилцааны нэг чухал элемент нь эмнэлзүйн харилцааны онцлог, эмнэлгийн мэргэжилтний сэтгэл зүйн менежмент юм. Сэтгэлийн хөдөлгөөн нь бие хүний өөрөө өөртөө хандаж буй хандлага болон хүрээлэн буй бодит орчинд хандаж буй хандлагын илрэл юм. харин мэдрэмж нь юмс үзэгдэлд хандах харьцангуй тогтвортой байнгын шинжтэй тухайн хүнд тогтсон төлөвшсөн чанар юм. Мэдрэмж нь харьцангуй тогтвортой гүн гүнзгий чанараараа ялгагддаг бол сэтгэлийн

хөдөлгөөн нь тухайн үед юмс үзэгдэлд хандах хандлагыг илэрхийлсэн түр зуурын шинжтэй үйл явц юм.

#### **Хичээлийн зорилго:**

Эмнэлзүйн харилцаанд оролцох, харилцааг удирдан явуулах, үйлчлүүлэгчийн сэтгэцийн байдлыг таньж мэдэх, сэтгэл хөдлөлөө удирдах арга барил болон эмнэлгийн мэргэжилтнүүдийн заавал эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлагад сургахад оршино.

#### **Заавал эзэмших мэдлэг**

- Сэтгэцийн эрүүл мэндийн сувилагч үйлчлүүлэгч хоёрын хувь хүний болон эмнэл зүйн харилцааны ёс зүй
- Эмнэлзүйн харилцаанд оролцогчдын хамтын хэрэгцээ, зорилго, сонирхол, эрмэлзэл, үнэт зүйл, үйл ажиллагааны арга барил, өөрчлөлт шинэчлэл
- Эмнэлзүйн харилцааны алдаатай байдал
- Сэтгэлийн хөдөлгөөн түүний төрөл, хэлбэр
- Сувилахуйн шинжлэх ухааны хөгжлийн түүх, онолчдын үзэл баримтлалын талаар мэдлэг эзэмших
- Сувилахуйн практик дахь орчны онолын (Найтингел), Маслоу онолын талаар мэдлэг эзэмших
- Эмнэлгийн аюулгүй орчин бүрдүүлэлтийг мэдэх

#### **Заавал эзэмших чадвар**

- Багийн удирдлага, зохион байгуулалтын тухай чадвар эзэмших
- Сэтгэцийн шинжүүдийн онцлогийг ялгах, харьцуулах чадвар
- Сэтгэн бодох, шийдвэр гаргах чадвар эзэмших
- Бусад оронд онолыг практикт нэвтрүүлсэн байдлыг өөрийн оронтой харьцуулах, судлах чадвар эзэмших
- Сувилахуйн онолын үзэл баримтлалд тулгуурлан нэгжийг удирдах, чиглүүлэх чадвар эзэмших

#### **Зайлшгүй эзэмших хандлага**

- Аливаа зүйлийг харьцуулах, дүгнэлт хийх хандлага төлөвших
- Ёс зүйтэй байх, хариуцлагаа ухамсарлах хандлага төлөвших
- Сувилахуйн мэргэжлийн мөн чанарыг ойлгох хандлага төлөвших
- Мэргэжлээрээ өсөн дэвших хандлага төлөвших

- Үйлчлүүлэгчдийн насны онцлог, хүйс, бие хүний хэв шинж, туулж өнгөрүүлсэн амьдрал, аливаа зүйлийг хүлээж авах чадвар, дасан зохицох чадвар нь өвчнийг даван туулахад чухал ач холбогдолтойг ойлгох хандлага
- Үйлчлүүлэгчийг зөвхөн бие махбодын хувьд бус сэтгэл санаа, оюун бодол, нийгэм гэх мэт олон талаас нь үнэлэх хандлага

## II МОДУЛИЙН ТОЙРОЛТЫН СУРГАЛТЫН ХЭЛБЭР: ДАДЛАГА

№	Тойролтын сэдэв	Тойролт хийх тасгийн нэр	Тойролтын Хугацаа цаг	Он сар өдөр
1	Эмнэлзүйн харилцаа, харилцааны ур чадвар	I-XI тасгуудад	4	II.23
2	Тасгийн доторхи аюулгүй орчин бүрдүүлэх	I-XI тасгуудад	8	II.24
3	Зан төлөв, түүний хурцдал, харилцааны стратеги	I-XI тасгуудад	8	III.25
4	Эмнэлзүйн харилцааны хэлбэрүүд, тэдгээрийн зэрэг ба сөрөг талууд, сөрөг харилцаанаас урьдчилан сэргийлэх нь	I-XI тасгуудад	4	II.26
5	Сэтгэцийн эрүүл мэндийн эмнэлзүйн харилцааны онцлог	I-XI тасгуудад	4	III.01
6	Эмнэлгийн ажилтнаас хамааралтай сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал, эмгэгээс урьдчилан сэргийлэх нь	I-XI тасгуудад	4	III.02

## II МОДУЛИЙН ХҮРЭЭНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ ГАРДАН ҮЙЛДЛИЙН ЖАГСААЛТ

№	<u>Гүйцэтгэх үйлдэл</u>	<u>Сонссон ба харсан түвшин</u>	<u>Хийсэн түвшин</u>	<u>Чадсан түвшин</u>	<u>Гүйцэтгэх тоо</u>	
	Сувилагч-Сувилагчтай харилцах	10	10	10	30	50
	Сувилагч- Эмч, бусад мэргэжилтнүүдтэй харилцах	10	10	10	30	50
	Сувилагч-Үйлчлүүлэгчтэй харилцах	10	10	10	30	30

Сувилагч-Ар гэрийнхэнтэй нь харилцах	10	10	10	30	30
Эерэг харилцааг удирдах чадвар (үйлчлүүлэгчийн үнэт зүйлийг хүндэтгэж харилцах)	10	10	10	30	30
Үр дүнтэй ярилцлага зохион байгуулах чадвар (Асуулт асуух чадвар, Сонсох чадвар)	10	10	10	30	30
Зөрчил зөрөлдөөнийг удирдан зохицуулах	10	10	10	30	30
Зан араншинд тохирч харилцах	10	10	10	30	60
Сувилагч өөрийн сэтгэл хөдлөлийг удирдах чадвар	10	10	10	30	60
Сэтгэцийн өөрчлөлттэй хүмүүстэй харилцах (хоолноос татгалзах эмгэг, хүчирхийлэлд өртсөн, догшрол, дэмийрэл, амиа хорлох сэдэлтэй, мансуурах бодис, донтолт, сэтгэл гутрал)	10	10	10	30	60

#### **Бие даалт:**

Дараах киног үзэж эерэг, сөрөг харилцаанд дүгнэлт хийх

- Анагаагч Адамс
- Ногоон бүс

#### **Сургалтын заах арга зүй:**

Дүрд тоглох, багаар ажиллах, интерактив, ярилцлагын хэлбэр, дэлхийн кафе, асуудалд суурилсан арга

#### **Сургалтын үнэлгээ:**

Семинар: Асуудалд суурилсан сургалт, LBL, дүрд тоглох, багаар ажиллах, эмнэл зүйн ур чадварын хэлэлцүүлэг, ЭССЭ бичих.

Эссэ бичүүлж, рубрикийн шалгуур хуудсаар үнэлнэ. Ярилцлага зохион байгуулж буйг үнэлгээний хуудсаар үнэлэх. Хичээл бүрийн төгсгөлд 5 асуулт бүхий тестээр үнэлнэ. (К хэлбэрийн тест-2, А хэлбэрийн тест-2, В хэлбэрийн тест-1)

#### **Хичээлийн төгсгөлд хүрэх үр дүн:**

##### **Мэдлэг – L3 түвшинд**

K1	Эмнэлзүйн харилцааны талаарх ойлголт, харилцааны соёл, ур чадвар, үүрэг, үйлчлүүлэгчийн хэрэгцээг тодорхойлно
K2	Эмнэлзүйн харилцааны итгэл үнэмшилд тулгуурлан харилцах арга барилын талаар мэдлэгтэй болно.
K3	Эмнэлзүйн харилцааны олон талт мэргэжилтнүүдийн хамтын ажиллагааны талаар мэдлэгтэй болно

K4	Эмнэлзүйн орчны тухай, аюулгүй орчныг хэрхэн бэлтгэх талаар мэдлэгтэй болно
K5	Эмнэлгийн мэргэжилтний заавал эзэмших харилцааны ур чадварын тухай болон хүн өөрт төрж буй мэдрэмжийг удирдаж чадахгүй ч зан үйлээрээ удирдан зохицуулж болох,
K6	Эмнэлгийн мэргэжилтэн сэтгэлийн хөдөлгөөн, мэдрэмж хоорондын ялгааны талаарх мэдлэгтэй болно
K7	Эмнэлгийн мэргэжилтэн өөрийн сэтгэл хөдлөлөө хэрхэн зөв удирдах талаар мэдлэгтэй болно
K8	Эмнэлзүйн харилцааны хэлбэр, эерэг-сөрөг харилцааны тухай, эмнэлгийн мэргэжилтний харилцаанд нөлөөлөлийн тухай
K9	Эмнэлгийн мэргэжилтний харилцааны алдаанаас хэрхэн сэргийлж болох талаар мэдлэгтэй болно
K10	Хүн амд сэтгэцийн эмгэгийн талаархи зөв ойлголт, зөв мэдээллийг өгөх талаар, сурталчилан таниулах үйл ажиллагааг зохион байгуулах талаар мэдлэгийг эзэмшинэ

#### **Чадвар – L3 түвшинд**

S1	Эмнэлзүйн харилцааны соёл, харилцааны арга барил, ур чадвартай болно.
S2	Үйлчлүүлэгчийн итгэл үнэмшилд тохируулан эмнэлзүйн харилцааг удирдан явуулах чадвартай болно.
S3	Эмнэлзүйн харилцааны орчинг бэлтгэх харилцааны явцад анхаарах, хяналт тавих чадварыг эзэмшинэ
S4	Сэтгэлийн хөдөлгөөнийг олон талаас нь тайлбарлах, сэтгэл хөдлөлөө удирдах, сангвиник, холерик, флегматик, меланхоик шинжүүдийн онцлогийг ялгах, харьцуулах чадварыг эзэмшинэ.
S5	Өөрийн зан төлөв, темпераментийг тодорхойлох чадварыг эзэмшинэ.
S6	Эерэг харилцааны арга барил, ур чадварт эзэмшинэ
S7	Эмнэлгийн ажилтнаас хамааралтай харилцааны алдаанаас сэргийлэх чадварыг эзэмшинэ.
S8	Нийгмийн дундахь сэтгэцийн эмгэгийн талаархи буруу ойлголт, сөрөг хандлагыг арилгах чадварт суралцана.

#### **Хандлага – L3 түвшинд**

A1	Эмнэлзүйн харилцааны орчинг тогтмол аюулгүй байлгахад анхаарч, зөв эерэг хандлагатай болно
A2	Өөрийн болон бусдын бие хүний хэв шинжийн онцлогийг хүндэтгэх хандлага
A3	Үйлчлүүлэгчийг сэтгэл санаа, оюун бодол, нийгмийн олон талаас нь үнэлэх хандлага
A4	Сувилагч-сувилагчийн хоорондын харилцаанд эерэг хандлага төлөвшинө.
A5	Сувилагч-үйлчлүүлэгчийн хоорондын харилцаанд гардаг үл ойлголцол арилж зөв хандлагатай болно.
A6	Сувилагч-ар гэр асран хамгаалагч хоорондын харилцаа болон үйлчлүүлэгчтэй харилцах харилцаанд эерэг, зөв хандлага бий болно
A7	Сэтгэцийн эмгэгийн талаархи буруу ойлголт, сөрөг хандлага, ялгаварлан гадуурхах байдал багасаж эерэг хандлага төлөвшинө.

### **МОДУЛЬ 3. СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ**

#### **Хичээлийн агуулга:**

Сүүлийн жилүүдэд сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээний эрэлт эрс нэмэгдсэн нь америкчууд эрүүл мэндийн даатгалд хамрагдсанаас, СЭМ-ийн тусламжийн тухай хуульд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх хэд хэдэн шаардлага тавигдсантай холбоотой юм. Дэлхий дээр 2014-2015 онуудад сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагчийн эрэлт хэрэгцээ эрс өссөн байна. Сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээний эрэлт хэрэгцээ нэмэгдэж, сэтгэцийн өвчтэй хүмүүсийг гутаан доромжлох байдал буурсан. Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж нь үйлчлүүлэгчийн эрүүл мэндийг үнэлэх, оношлох, төлөвлөх, дүгнэх зэргээр тухайн хүнд чиглэсэн сувилахуйн тусламжийг үзүүлдэг бөгөөд Tee et al, 2012 сэтгэцийн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг сурталчлах, тэдний эрхийг нь хүндэтгэн тусламж үзүүлэх байдлыг хэлнэ. Сэтгэцийн эрүүл мэндийн сувилагч мэргэжилтнүүд нь хүмүүсийн оюун санаа, бие бялдрын тал дээр бүрэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлдэг. Сэтгэцийн сувилагч нар илүү их туршлага, мэдлэг олж авахын хэрээр сэтгэцийн эрүүл мэндийн сувилагчийн үүрэг хариуцлага нэмэгддэг. Сэтгэцийн мэргэшсэн сувилагч нь шаардлагатай тохиолдолд үйлчлүүлэгчийн эмэнд хяналт тавих, хуваарилах, тараах, үнэлгээ хийх, үйлчлүүлэгч болон тэдний гэр бүлд зөвлөгөө өгөх чадварыг эзэмшсэн байдаг.

#### **Заавал эзэмших мэдлэг:**

- Сэтгэцийн сувилахуйн онолууд, түүний ерөнхий ойлголт, онолчдын тухай
- Сэтгэцийн эмгэгийн оношилгоо, эмчилгээний тухай ерөнхий ойлголт, олон улсын чиг хандлага
- Сэтгэцийн эмгэгийн эмчилгээний менежмент, эмчилгээний зохицлын талаарх ойлголт, олон улсын чиг хандлага
- Наркологи, донтох эмгэгийн оношилгоо, жорын болон жорын бус эмийн эмчилгээнд сувилагчийн оролцоо, үүрэг
- Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний инноваци, сувилагчийн манлайлал

- Хамтарсан багийн гишүүний хувьд сувилагч эмчлүүлэгчийн эрүүл мэндийн байдлыг үнэлэх нь (сэтгэцийн, сэтгэл зүйн, бие махбодын, орчны, аюулгүй байдал, эрсдэлийн үнэлгээ)
- Нотолгоонд суурилсан сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг удирдлагаар хангахад сувилагчийн оролцоо, тусламж үйлчилгээний чанарыг үнэлэх модел, арга аргачлал
- Чанарын тухай ойлголт, сувилахуйн тусламжийн чанар хүртээмжийг нэмгэдүүлэх нь
- Улс орны соёлд тохирохуйц/ хувь хүнд тохируулсан тусламж үйлчилгээний талаарх ойлголт
- Нийгэм, соёл, гэр бүлийн нөлөөний талаарх нотолгоотой мэдлэг эзэмших

#### **Хичээлийн зорилго:**

Сэтгэцийн эрүүл мэндийн сувилагчийн эзэмшвэл зохих ур чадвар, тусламж үйлчилгээний чанар, эмчлүүлэгчийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох, биемахбодын эрүүл мэндийн байдал, орчны аюулгүй байдал, эрсдлийн үнэлгээ, сэтгэцийн эмгэгийг оношлох аргууд, оношлогоо, эмчилгээний менежмент, нотолгоонд суурилсан сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээ, үйлчлүүлэгчдийг улс орны соёлд нь тохируулсан тусламж үйлчилгээг үзүүлэх талаарх мэдлэг эзэмшинэ

#### **Заавал эзэмших чадвар**

- Сэтгэцийн эмгэгүүдийн үеийн сувилахуйн тусламж үйлчилгээ үед үзүүлэх сувилахуйн өвөрмөц тусламж үйлчилгээ
- Донтох эмгэгийг үнэлэх олон улсын шалгуур, үнэлгээ, хоргүйжүүлэх эмчилгээ, сувилгаа
- Багаар болон бүлгээр ажиллах чадвар
- Хувь хүний хямралыг зохицуулах арга техник
- Стресс, сэтгэцийн байдал, өөрийгөө ойлгох, дасан зохицох, даван туулах, мансууруулах бодис хэрэглэсэн үйлчлүүлэгчийг сувилагч үнэлэх чадвар
- Цогц үнэлгээ хийх чадвар (бие бялдар, сэтгэцийн эрүүл мэнд, нийгмийн, оюун санааны, хөгжлийн болон соёлын)
- Үнэлгээний мэдээлэлд үндэслэн эмнэлзүйн дүгнэлтийг боловсруулах чадвар (сувилахуйн оношлогоо, дүгнэлт)

- Эмчилгээний аргын талаарх мэдлэгийн гэр бүл, асран хамгаалагчдад өгөх зөвлөгөө
- Аюулгүй байдлыг үнэлэх чадвар эзэмших
- Сэтгэн бодох, шийдвэр гаргах чадвар эзэмших
- Тэмдэглэл хөтлөх, хяналт тавих, тойм бичих, шүүмжлэлтэй дүн шинжилгээ хийх чадвар
- Эх сурвалжаас авсан нотлох баримтыг эргэцүүлэн, судалгаа хийх чадвар эзэмших

#### **Зайлшгүй эзэмших хандлага**

- Сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн эрхийг хүндэтгэх
- Үйлчлүүлэгчийг хүндлэх, түүний мэдрэмжийг ойлгох
- Үйлчлүүлэгчийг нэрээр нь дуудаж хүндэтгэн харилцах
- Үйлчлүүлэгчийн ар гэр, асран хамгаалагчийг хүндэтгэх
- Хувь хүний нууцыг чанд хадгалах
- Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, донтолтыг бууруулах зорилгоор үндэсний хэмжээнд хэрэгжиж байгаа хууль, хөтөлбөр, тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх
- Сэтгэцийн эрүүл мэндийн идэвхижүүлэх дэглэмийг баримтлах
- Эерэг хандлагатай байх
- Хүнлэг энэрэнгүй, өрөвч нинжин сэтгэлтэй байх, нийцтэй байх
- Аман ба аман бус харилцааг ашиглах

#### **Зайлшгүй суралцах бие даалтын сэдвүүд:**

- Дэлхийн хүн амын сэтгэцийн эрүүл мэндийн асуудлуудын талаарх шинэ мэдээлэл
- Сэтгэцийн сувилахуйн тусламжийн талаарх сувилахуйн судалгаа
- Сэтгэцийн эрүүл мэндийн сувилагчийн ажлын байрны тодорхойлолт
- Сэтгэцийн сувилагчийн бүртгэл, интернэт орчинд ажиллах нь

#### **III МОДУЛИЙН ТОЙРОЛТЫН СУРГАЛТЫН ХЭЛБЭР: ДАДЛАГА**

№	Тойролтын сэдэв	Тойролт хийх тасгийн нэр	Тойролтын хугацаа	Он сар өдөр
1	Сэтгэцийн эмгэгтэй үйлчлүүлэгчийг үнэлэх нь /нийгэм, сэтгэл зүй, бие махбодь/	I-XI тасгуудад	8	18/III



2	Сэтгэцийн эмгэгтэй үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, эрсдлийн үнэлгээ /орчин, үйлчлүүлэгч, тусламж үзүүлэгч/	I-XI тасгуудад	8	19/III
3	Сэтгэцийн эмгэгийн оношлогооны тухай /ажиглалт, асуумж, сорил, бодит үзлэг/	I-XI тасгуудад	8	22/III
4	Сэтгэцийн эмгэгийн оношилгоонд сувилагчийн оролцоо	I-XI тасгуудад	8	23/III
5	Сэтгэц нөлөөт эмийн тухай ойлголт, эмчилгээний менежмент	I-XI тасгуудад	8	24/III
6	Эмийн бус эмчилгээнд сувилагчийн оролцоо	I-XI тасгуудад	4	17/III
7	Сэтгэцийн нөлөөт эмийн эмчилгээний зохицолын тухай ойлголт	I-XI тасгуудад	4	25/III
8	Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн сувилагчийн зайлшгүй эзэмшвэл зохих ур чадварууд, онцлог	I-XI тасгуудад	4	29/III
9	Нотолгоонд суурилсан тусламж үйлчилгээг практикт хэрэглэх нь	I-XI тасгуудад	4	30/III
10	Нотолгоонд суурилсан сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламжийн орчин үеийн чиг хандлага	I-XI тасгуудад	4	31/III
11	Эмийн бус эмчилгээнд сувилагчийн ур чадвар	I-XI тасгуудад	4	5/IV

### III МОДУЛИЙН ХҮРЭЭНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ ГАРДАН ҮЙЛДЛИЙН ЖАГСААЛТ

№	Гүйцэтгэх үйлдэл	Сонссон ба харсан түвшин	Хийсэн түвшин	Чадсан түвшин	Гүйцэтгэх тоо
1	Ажиглалт /нийгэм, биеийн, сэтгэлзүйн/		+		10
2	Сэтгэцийн байдлыг шалгах хуудас			+	10
3	Сэтгэцийн байдлыг үнэлэх үнэлгээ /ММЕТ/		+		10
4	Сувилгааны түүх хөтлөлт дээр тэмдэглэл хийх		+		10

5	Орчны аюулгүй байдлыг үнэлэх үнэлгээ			+	10
6	Сэтгэцийн эмгэгтэй хүний орчны стандарт		+		10
7	Эрсдлийн үнэлгээ			+	20
8	Эрсдлийг үнэлэх үнэлгээний асуумж			+	10
9	Эмчлүүлэгчийн сувилгааны түүх хөтлөх			+	10
10	Сэтгэцийн эмгэгийн үеийн эмчилгээнд сувилагчийн оролцоо	+			10
11	Сэтгэцийн эмгэг илрүүлэх сорилууд			+	10
12	Нотолгоонд суурилсан тусламж үйлчилгээг удирдлагаар хангахад сувилагчийн оролцоо		+		10
13	Сэтгэцийн эрүүл мэндийн сувилагчийн удирдлага, манлайлал			+	10
14	Сэтгэцийн сувилагчийн манлайлалд хамт олны дэмжлэг			+	10
15	Чанарын тухай ойлголт, олон улсын чиг хандлага			+	10
16	Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээг үнэлэх ДЭМБ-ын аргачлал			+	10
17	Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээний чанарын төлөвлөлт			+	10
18	Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээний чанарын хяналт, үнэлгээ	+			10
19	Улс орнуудын соёлын тухай ойлголт			+	10
20	Үйлчлүүлэгчийн үнэт зүйлийг хүндэтгэн харилцах нь			+	10
21	Үйлчлүүлэгчийн итгэл үнэмшил, зан заншилд тохируулан сувилахуйн тусламж үзүүлэх нь			+	10
22	Хувь хүний сэтгэлзүйн онцлогт тохирсон сувилгаа хийх		+		10

**Сургалтын арга:**

Лекц: Танхим, онлайн интерактив хэлбэрээр

Семинар: Асуудалд суурилсан сургалт, LBL, дүрд тоглох, багаар ажиллах, эмнэл зүйн ур чадварын хэлэлцүүлэг

**Сургалтын үнэлгээ:**

Хичээлийн ирц-10%

Хичээлийн явц-60% (багийн даалгавар-20%, хичээлийн идэвх, оролцоо-20%, Эссэ-20%) хичээлийн төгсгөлд төгсөлтийн тест – 30%

**Хичээлийн төгсгөлд хүрэх үр дүн:**

<b>Мэдлэг – L3 түвшинд</b>	
K1	Сэтгэцийн эрүүл мэндийн сувилагчийн эзэмшвэл зохих ур чадвар, тусламж үйлчилгээний талаарх мэдлэгтэй болно
K2	Эмчлүүлэгчийн биемахбодын эрүүл мэндийн байдал, орчны аюулгүй байдлын талаарх мэдлэгтэй болно
K3	Сувилагч эмчлүүлэгчийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох, эрсдлийн талаарх мэдлэгтэй болно
K4	Сэтгэцийн эмгэгийг оношлох аргууд, оношлогоо, эмчилгээний талаарх мэдлэгтэй болно
K5	Сэтгэцийн эмгэгийн эмчилгээний тухай ойлголт, эмчилгээний менежмент мэдлэгтэй болно
K6	Нотолгоонд суурилсан сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаарх мэдлэгтэй болно
K7	Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээний чанарын талаарх мэдлэгтэй болно
K8	Улс орны соёлд тохирохуйц хувь хүнд тохируулсан сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаарх мэдлэгтэй болно
<b>Чадвар – L3 түвшинд</b>	
S3	Орчны аюулгүй байдлыг үнэлэх чадвар эзэмшинэ
S4	Сэтгэцийн эмгэгтэй хүний орчны стандарт
S5	Эрсдлийн үнэлгээг хийх чадвар эзэмшинэ
S6	Нотолгоонд суурилсан сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх чадвар эзэмшинэ
S7	Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээний чанарын хяналт, үнэлгээг хийх чадвар эзэмшинэ
S8	Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлэхэд багаар ажиллах чадвар эзэмшинэ
S9	Тухайн хүнийг өрөвдөхгүй, шүүмжлэхгүй, буруутгахгүйгээр тусламж үзүүлэх чадвар эзэмшинэ
<b>Хандлага – L3 түвшинд</b>	
A1	Сэтгэцийн эмгэгтэй үйлчлүүлэгчдийн үнэт зүйлсийг эрхэмлэн харилцах
A2	Үйлчлүүлэгчийг бүрэн сонсох чадвар эзэмшинэ
A3	Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай үйлчлүүлэгчид тусламж үзүүлэхдээ чин сэтгэлээсээ, хөнгөн шуурхай үйлчилж, хандах

A4	Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай үйлчлүүлэгч, тэдний ар гэрийнхэнтэй харилцааны тохирох аргыг сонгож, эерэг харилцааг бий болгох
A5	Үйлчлүүлэгчид туслах гэж буйгаа мэдрүүлэх
A6	Аливаа асуудалд багаараа хамтран шийдвэрлэх
A7	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд оролцогч талуудын эрх, үүргийг мөрдөх
A8	Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай үйлчлүүлэгчтэй харилцахдаа тэдний байр сууринд өөрийгөө тавьж, асуудалд хандах
A9	Сэтгэцийн эмгэгтэй үйлчлүүлэгчийн эрхийг дээдлэх, хамгаалах

#### **МОДУЛЬ 4. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ОРОЛЦОО, ХАМТЫН АЖИЛЛАГАА, НӨХӨН СЭРГЭЭХ ЗАГВАР**

##### **Хичээлийн агуулга:**

Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд үйлчлүүлэгч, түүний ар гэрийнхэнийг татан оролцуулснаар үйлчлүүлэгч өөртөө итгэх итгэл, биеэ даан үйл ажиллагаанд оролцох, багаар хамтран ажиллах, шийдвэр гаргах, нийгэмд дасан зохицох чадварыг нотолгоонд тулгуурлан сайжруулж үйлчлүүлэгчийн өөрийн болон бусад эмчлүүлэгчдийн өвчний дахилтаас сэргийлж, үйлчлүүлэгчийн сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалахад гэр бүлийнхний оролцоог нэмэгдүүлэхэд оршино. Сэтгэцийн эмгэгтэй хүний талаарх хууль, эрхзүйн ойлголтуудыг сайжруулснаар үйлчлүүлэгч болон энэхүү харилцаанд оролцогч талууд өөрсдийн эрх ашгийг хамгаалах, эрх эдлэх, хүлээх үүргийн хүрээнд хууль эрхзүйн биелэлтэнд тавих хяналтыг сайжруулж, сэтгэцийн эмгэгтэй хүнийг ялгаварлан гадуурхах, муу нэрийн шошго зүүх үзэгдлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

##### **Хичээлийн зорилго:**

Сэтгэцийн эмгэгтэй хүнд сэтгэц нийгмийн нөхөн сэргээх эмчилгээг хийснээр хөдөлмөрийн болон өдөр тутмын ажлын чадвараа алдахаас урьдчилан сэргийлэх, алдагдсан чадварыг сэргээх, шинээр ур чадваруудыг сургах, нийгэмд дасан зохицох чадварыг сайжруулах, алдагдсан нэр төрийг сэргээх, нийгэмд аюултай үйлдэл хийхээс урьдчилан сэргийлнэ.

##### **Заавал эзэмших мэдлэг:**

- Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд оролцогч, түүнийг үүргийн талаарх
- Хөндөгдөх ёс зүйн асуудлууд

- Үйлчлүүлэгчийг татан оролцуулах тулд хувь хүний эдлэх эрх, сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийн тухай
- Манай улсад хууль эрх зүйн хэрэгжилтийг сайжруулах
- Сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хамгаалах, дэмжихэд сувилагчийн оролцоо
- Сэтгэц нийгмийн нөхөн сэргээх эмчилгээний тухай, реабилитацийн хэлбэрүүд
- Эмнэлэг хамгааллын дэглэм

Сэтгэц нийгмийн реабилитаци эмчилгээнд тасгийн сувилагчийн гүйцэтгэх үүрэг

#### **Заавал эзэмших чадвар**

- Эмчлүүлэгчийн эмчилгээний үр дүнг үнэлэх
- Сэтгэц нийгмийн нөхөн сэргээх эмчилгээ хэрхэн удирдах
- Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд үйлчлүүлэгчийг урамшуулах
- Үйлчлүүлэгчийг хэрхэн татан оролцуулах талаар мэдлэгтэй болох
- Нөхөн сэргээх модел болон практикт хэрэгжилт
- СЭМ-ийн тусламж үйлчилгээнд үйлчлүүлэгчийг татан оролцуулах, хамтран ажиллах арга барил

#### **Зайлшгүй эзэмших хандлага**

Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг баримтлан, харилцааны өндөр соёлтой байх

- Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдал, ар гэрийнхний нийгэмд эзлэх байр суурийг үл харгалзан хүнлэг энэрэнгүй, чин сэтгэлээсээ хандаж сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлэх
- Хамтран ажилладаг бусад мэргэжил нэгт нөхөд болон үйлчлүүлэгч, тэдний ар гэрийнхнийг ойлгодог байх

#### **IV МОДУЛИЙН ТОЙРОЛТЫН СУРГАЛТЫН ХЭЛБЭР: ДАДЛАГА**

№	Тойролтын сэдэв	Тойролт хийх тасгийн нэр	Тойролтын Хугацаа цаг	Он сар өдөр
1	Сэтгэцийн эмгэгтэй хүний эдлэх эрх, хэрэгжих боломж, хязгаарлагдмал байдал	I-XI тасгуудад	4	19/IV
2	Монгол улс дахь сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийн хэрэгжилтийн өнөөгийн байдал	I-XI тасгуудад	4	20/IV
3	Сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хамгаалах, дэмжих тусламж үйлчилгээ	I-XI тасгуудад	4	21/IV

4	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд үйлчлүүлэгчийг татан оролцуулахтай холбоотой ёс зүйн хэм хэмжээ	I-XI тасгуудад	4	22/IV
5	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламжид үйлчлүүлэгчийг татан оролцуулахад тулгарах бэрхшээл, түүнийг даван туулах	I-XI тасгуудад	4	22/IV
6	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд үйлчлүүлэгчийг татан оролцуулах аргууд	I-XI тасгуудад	4	23/IV
7	Үйлчлүүлэгчийг сонгох, Сэтгэцийн эрүүл мэндийн тусламжид үйлчлүүлэгчийн оролцоо	I-XI тасгуудад	4	23/IV
8	Нөхөн сэргээх эмчилгээний орчин үеийн чиг хандлага, олон улсын туршлага	I-XI тасгуудад	8	26/IV

#### IV МОДУЛИЙН ХҮРЭЭНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ ГАРДАН ҮЙЛДЛИЙН ЖАГСААЛТ

№	Гүйцэтгэх үйлдэл	Сонссон ба харсан түвшин	Хийсэн түвшин	Чадсан түвшин	Гүйцэтгэх тоо
1	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд үйлчлүүлэгчийг татан оролцуулах аргуудыг ашиглах			30	
2	СЭМ-ийн тусламжид үйлчлүүлэгчийн оролцуулах үйл ажиллагаа явуулах			30	
3	Сэтгэцийн эмгэгтэй үйлчлүүлэгчдэд сэтгэц нийгмийн нөхөн сэргээх эмчилгээг хийж сурах			30	
4	Сэтгэцийн эмгэгтэй үйлчлүүлэгчдэд эмнэлэг хамгааллын дэглэмийг хэрэгжүүлэх			30	

#### Сургалтын арга:

Лекц: Танхим, онлайн интерактив хэлбэрээр

Семинар: Асуудалд суурилсан сургалт, LBL, дүрд тоглох, багаар ажиллах, эмнэл зүйн ур чадварын хэлэлцүүлэг

## Сургалтын үнэлгээ:

Хичээлийн ирц-10%

Хичээлийн явц-60% (багийн даалгавар-20%, хичээлийн идэвх, оролцоо-20%, Эссэ-20%) хичээлийн төгсгөлд төгсөлтийн тест – 30%

## Хичээлийн төгсгөлд хүрэх үр дүн:

<b>Мэдлэг – L3 түвшинд</b>	
K1	Сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн эрхийн тухай хууль, эрхзүйн асуудлууд, хэрэгжилт
K2	Сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хамгаалах, дэмжих тусламж үйлчилгээ
K3	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд оролцогч талууд, тэдгээрийн үүрэг оролцоо, ёс зүйн асуудлууд
K4	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд үйлчлүүлэгчийг татан оролцуулах, хамтран ажиллах хэлбэрүүд
K5	Нөхөн сэргээх эмчилгээний тухай ерөнхий ойлголт, үндсэн зарчмууд, олон улсын туршлага
K6	Нөхөн сэргээх эмчилгээний хамрах хүрээ, хэлбэрүүд, тэдгээрийн онцлог
K7	Сэтгэцийн үйлчлүүлэгчийн эмнэлэг хамгааллын дэглэм
K8	Сэтгэцийн үйлчлүүлэгчийн нөхөн сэргээх эмчилгээний ач холбогдол, эмчилгээний үр дүнг тооцох аргууд
<b>Чадвар – L3 түвшинд</b>	
S3	Нөхөн сэргээх эмчилгээг явуулах
S4	Сэтгэцийн үйлчлүүлэгчийн эмнэлэг хамгааллын дэглэмийг сахах
S5	Сэтгэцийн үйлчлүүлэгчийн нөхөн сэргээх эмчилгээний ач холбогдол, эмчилгээний үр дүнг тооцож сурах
S6	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд үйлчлүүлэгчийг татан оролцуулж, хамтран ажиллах
S7	Сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хамгаалах, дэмжих
S8	Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлэхэд багаар ажиллах чадвар эзэмшинэ
S9	Тухайн хүнийг өрөвдөхгүй, шүүмжлэхгүй, буруутгахгүйгээр тусламж үзүүлэх чадвар эзэмшинэ
<b>Хандлага – L3 түвшинд</b>	
A1	Сэтгэцийн эмгэгтэй үйлчлүүлэгчдийн үнэт зүйлсийг эрхэмлэн харилцах
A2	Үйлчлүүлэгчийг бүрэн сонсох чадвар эзэмшинэ
A3	Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай үйлчлүүлэгчид тусламж үзүүлэхдээ чин сэтгэлээсээ, хөнгөн шуурхай үйлчилж, хандах
A4	Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай үйлчлүүлэгч, тэдний ар гэрийнхэнтэй харилцааны тохирох аргыг сонгож, эерэг харилцааг бий болгох
A5	Үйлчлүүлэгчид туслах гэж буйгаа мэдрүүлэх
A6	Аливаа асуудалд багаараа хамтран шийдвэрлэх
A7	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд оролцогч талуудын эрх, үүргийг мөрдөх
A8	Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай үйлчлүүлэгчтэй харилцахдаа тэдний байр сууринд өөрийгөө тавьж, асуудалд хандах
A9	Сэтгэцийн эмгэгтэй үйлчлүүлэгчийн эрхийг дээдлэх, хамгаалах

## **МОДУЛЬ 5. СЭТГЭЦИЙН ХЯМРАЛЫН ҮЕИЙН ЭМНЭЛЗҮЙН МЕНЕЖМЕНТ, ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ**

### **Хичээлийн агуулга:**

Сэтгэцийн хурц байдалтай үйлчлүүлэгч, тэдний ар гэр, асран хамгаалагч, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэгч нарын аюулгүй байдал ихээхэн чухал байдаг. Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэгч нь үйлчлүүлэгч болон өөрийгөө, хамтран ажиллагсадаа, хохирол амсах магадлалтай хэн бүхнийг хамгаалах үүрэгтэй. Эмнэлгийн тусламж үйлчилгээнийг сэтгэцийн яаралтай тусламж шаардлагатай хурц дошгирол, хий үзэгдэл дэмийрэлтэй, солиоролын эмгэг, амиа хорлох оролдлого зэрэг эмгэгийн үед хэрэгжүүлэх бичиг баримтыг бий болгох нь чухал юм. Амиа хорлох магадлалтай, бусдад хүчирхийлэх, түрэмгийлэх оролдлогыг урьдчилан таамаглах нь хэцүү. Бусад эрсдэлт хүчин зүйлүүдэд мансууруулах бодис, архи согтууруулах ундааны хэрэглээ гэмт хэрэг үйлдсэн өгүүлэмжтэй, хүүхэд байхдаа хүчирхийлэлд өртөж байсан өгүүлэмжтэй зэрэг багтана. Хэвтэн эмчлүүлэх эмнэлгийн нөхцөлд бусдад сэтгэцийн хурц эмгэгийн улмаас аюул заналхийлж, сүрдүүлж, хүчирхийлэл үйлдэж байгаа үйлчлүүлэгчдэд тохиолддог. Мөн тэднийг гаднаас харж ажиглах, харилцан харилцаж, бодит үзлэг хийх, гадаад төрх байдал үнэлгээ өгөх боловч бусдад гэнэтийн хүчирхийлэл үйлдэх, айлган сүрдүүлэх тохиолдож болзошгүй тул скрининг дүгнэлт хийж, илүү дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулах төлөвлөгөө, эрсдлийг үнэлж, анхааруулах талаар шийдвэр гаргах, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө гаргах зэрэг үйл ажиллагааг багтаасан бичиг баримт байх шаардлагатай.

### **Хичээлийн зорилго:**

Сэтгэцийн хурц байдалтай үйлчлүүлэгч, хүүхэд, өсвөр нас, харих насны сэтгэцийн эрүүл мэнд, бэлгийн эрүүл мэндийн асуудлуудтай хүмүүстэй ярилцлага хийх дистрессийн үеийн сэтгэлзүйн байдлыг үнэлэх, сэтгэцийн байдлыг үнэлгээ хийх менежмент, эмнэлгийн тасгуудад эрсдэлийг бууруулах, түрэмгийллийг намжаах, хямралын төлөвлөгөө боловсруулж, ашиглах яаралтай тусламжийг үзүүлэх, орчинд аюулгүй, үр дүнтэй дадлага хийх шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэхэд оршино.

### **Заавал эзэмших мэдлэг:**



- Сэтгэцийн яаралтай тусламжийн талаар мэдлэгтэй болох, сэтгэцийн эмгэгтэй үйлчлүүлэгчдийн сэтгэц, биеийн эрүүл мэндийн үнэлгээ хийх
- Сэтгэцийн яаралтай тусламжийн тасаг сэтгэцийн эмгэгтэй үйлчлүүлэгчдийн хүлээлгэн өгөх
- Сэтгэцийн хурц байдалтай байгаа үйлчлүүлэгчийн хүчирхийлэл, түрэмгийлэлийг намжаах төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх
- Сэтгэцийн эмгэгтэй эрсдлийн төлөвлөгөө боловсруулах, үнэлэх, бууруулах эмнэлзүйн мэдлэгтэй болох
- Сэтгэцийн эмнэлгийн яаралтай тусламжийн тасагт сэтгэцийн эмгэгтэй үйлчлүүлэгчдийн яаралтай тусламжийн эрэмбэлэн ангилал хийх
- Сэтгэцийн эмнэлэгт хэвтлүүлэх талаарх үйлчлүүлэгчийг дээдлэн хүндлэлтэй харьцах, үйлчлүүлэгчийн эрхийг дээдлэх

#### **Заавал эзэмших ур чадвар:**

- Сэтгэцийн эмгэгтэй хүнд яаралтай тусламж, эмнэл зүйн менежмент хийж сурах
- Тусгаарлалт, хязгаарлалтыг стандартын дагуу хийж сурах
- Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлж сурах
- Сэтгэцийн эмгэгтэй хүнд ажиглалт хийх, эрсдлийн үнэлэх, хэрэгжүүлэх, аюулгүй байдлыг хангах
- Өөртөө болон бусдад хохирол учруулах эрсдлийг үнэлэх
- Сэтгэцийн хурц байдалтай үйлчлүүлэгчийг багаар асуудлыг интервенц хийж, урьдчилан сэргийлэх менежмент хийж сурах
- Үйлчлүүлэгчийн ар гэрийнхэнтэй хамтран, аюулгүй байдлыг ханган, эрсдэлгүй харилцаа тогтоон, зөвөлгөө өгөх

#### **Зайлшгүй эзэмших хандлага**

- Үйлчлүүлэгчтэй нээлттэй, шударга харилцаа тогтоох
- Үйлчлүүлэгчийн бие даасан байдлыг ханган, ёс зүйн хувьд хүнлэг, энэрэнгүй байдлаар харилцах
- Үйлчлүүлэгчтэй хүндлэлтэйгээр, хүний эрхийг дээдлэн нууцыг хадгалах
- Багаар хамтран ажиллах
- Ар гэрийнхний нийгэмд эзлэх байр суурийг үл харгалзан хүнлэг энэрэнгүй, чин сэтгэлээсээ хандаж сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлэх

- Хамтран ажилладаг бусад мэргэжил нэгт нөхөд болон үйлчлүүлэгч, тэдний ар гэрийнхнийг ойлгодог байх

**V МОДУЛИЙН ТОЙРОЛТЫН СУРГАЛТЫН ХЭЛБЭР: ДАДЛАГА**

№	Тойролтын сэдэв	Тойролт хийх тасгийн нэр	Тойролтын Хугацаа цаг	Он сар өдөр
1	Эмнэлгийн орчин дахь сэтгэцийн хурц байдалтай үйлчлүүлэгчийг тухайн үеийн сэтгэцийн байдлыг үнэлэх, менежмент	I-XI тасгуудад	16	19-24 /V
2	Сэтгэлийн гэмтлийн дараах хариу урвалын үеийн тусламж үйлчилгээ	I-XI тасгуудад	16	25-28 /V
3	Эмнэлгийн тасгуудад хүчирхийлэл, түрэмгийлэл, бусдад аюултай үйлдэл, оргох, сэтгэц хөдөлгөөний дошгирол, мансууруулах бодисын цочмог хордлого, хоолноос татгалзах, уналт, таталтын байдал эмгэгүүдийн үеийн яаралтай тусламжийн эрсдлийн үнэлгээ хийж, гардан тусламж үзүүлэх /хурц тасгуудад/	I-XI тасгуудад	16	30/V - 04 /VI
4	Эмнэлгийн тасгуудад эрсдэлийг бууруулах зорилгоор амиа хорлох, хурц догшрол, хоолноос татгалзах, кататоник хөшилтийн үеийн түрэмгийллийг намжаах /хурц тасгуудад/	I-XI тасгуудад	12	07-08 /VI
5	Хүчирхийлэл, түрэмгийллийн үйлчлүүлэгчдэд сэтгэлзүйн байдлыг үнэлэх, сэтгэлзүйн байдлыг үнэлэн, хямралын төлөвлөгөө ашиглах яаралтай тусламжийг үзүүлэх /яаралтай тусламжийн тасагт/	I-XI тасгуудад	12	08-09 /VI
6	Дистрессийн үеийн сэтгэлзүйн байдлыг үнэлэх, сэтгэлзүйн байдлыг үнэлэн, хямралын төлөвлөгөө ашиглах яаралтай тусламжийг үзүүлэх	I-XI тасгуудад	12	10-11 /VI
7	Амиа хорлох эмгэгийн үеийн сэтгэлзүйн байдлыг үнэлэх, сэтгэлзүйн байдлыг үнэлэн, хямралын төлөвлөгөө ашиглах яаралтай тусламжийг үзүүлэх	I-XI тасгуудад	12	11-14 /VI

8	Бусад сэтгэцийн эмгэгийн сэтгэлзүйн байдлыг үнэлэх, сэтгэлзүйн байдлыг үнэлэн, хямралын төлөвлөгөө ашиглах яаралтай тусламжийг үзүүлэх	I-XI тасгуудад	12	15-16 /VI
9	Анхаарах өрөө, тусгаарлах өрөөнд аюулгүй орчинг бүрдүүлж, үйлчлүүлэгчийг хянах, тусламж үзүүлэх, ээлжинд хонож, сувилагч ээлж хүлээлцэх аргуудад дадлагажих /эмнэлгийн бүх тасгуудад/	I-XI тасгуудад	8	16-17 /VI
10	Хүүхэд, өсвөр нас, харих насны сэтгэцийн эрүүл мэнд, бэлгийн эрүүл мэндийн асуудлуудтай хүмүүстэй ярилцлага хийх, хямралын төлөвлөгөө ашиглах яаралтай тусламжийг үзүүлэх	I-XI тасгуудад	12	17-18 /VI

#### V МОДУЛИЙН ХҮРЭЭНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ ГАРДАН ҮЙЛДЛИЙН ЖАГСААЛТ

№	Гүйцэтгэх үйлдэл	Сонссон ба харсан ТҮВШИН	Хийсэн ТҮВШИН	Чадсан ТҮВШИН	Гүйцэтгэх тоо
1	Сэтгэцийн байдалд үнэлгээ хийх			+	10
2	Гэмтлийн дараах хариу урвалын үеийн тусламж үзүүлэх			+	10
3	Сэтгэцийн эмгэгүүдийн үеийн эрсдлийн үнэлгээ хийж, гардан тусламж үзүүлэх			+	10
4	Эмнэлгийн тасгуудад түрэмгийллийг намжаах аргуудыг хийж сурах			+	10
5	Хүчирхийлэл, түрэмгийллийн үйлчлүүлэгчдэд яаралтай тусламжийг үзүүлэх			+	10
6	Дистрессийн үеийн сэтгэлзүйн байдлыг үнэлэх, яаралтай тусламжийг үзүүлэх			+	10
7	Амиа хорлох үеийн хямралын төлөвлөгөө ашиглах яаралтай тусламжийг үзүүлэх			+	20
8	Хурц догшрол эмгэгийн хямралын төлөвлөгөө ашиглах яаралтай тусламжийг үзүүлэх			+	10
9	Хоолноос татгалзах эмгэгийн хямралын төлөвлөгөө			+	10

	ашиглах яаралтай тусламжийг үзүүлэх				
10	Кататоник хөшилт эмгэгийн хямралын төлөвлөгөө ашиглах яаралтай тусламжийг үзүүлэх			+	10
11	Анхаарах өрөөнд аюулгүй орчинг бүрдүүлж, үйлчлүүлэгчдэд хяналт тавих			+	10

### **Сургалтын хугацаанд зайлшгүй суралцах бие даалтын сэдвүүд**

1. Сэтгэцийн эмгэгтэй хүний эдлэх эрх, тэдгээрийн хэрэгжилтийн талаар багаар ажиллан асуумж боловсруулж судалгаа хийж үр дүнг танилцуулна
2. Хүүхдийн насны үе шатууд
3. Төрсний дараах солиорол
4. Тайлбарлаж боломжгүй биеийн эмгэгүүд
5. Психоанализын онол

### **Сургалтын арга:**

**Лекц:** Танхим, онлайнаар интерактив аргаар явуулах

**Семинар:** Асуудалд суурилсан сургалт, LBL, дүрд тоглох, багаар ажиллах, эмнэл зүйн ур чадварын хэлэлцүүлэг

**Дадлага:** Сургалтын дадлагыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв үндсэн I-XI дүгээр тасгуудад хувиарлагдан, үйлчлүүлэгчдэд аюулгүй орчинг бүрдүүлж, үйл ажиллагаанд гардан оролцож, дадлагажуулна.

- Мэргэжилтэн эмнэлзүйн дадлага
- Эмнэлзүйн дадлагын манлайлал
- Эмнэлзүйн дадлагын хөгжил
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, сэтгэцийн тусламж үйлчилгээ үзүүлж буйг харгалзан дүгнэх

**Үнэлгээний арга, хэлбэр:** Хяналтын хуудас, сорилын үнэлгээг ашиглана.

№	Үзүүлэлт	Авбал зохих рейтинг оноо /авбал зохих оноог тавьж өгнө/	
1	Лекц	10%	10 оноо
2	Дадлагын гардан үйлдлийн чадвар	30%	40 оноо
3	Дадлагын гардан үйлдлийн үнэлгээ	20%	10 оноо
4	Шалгалтын оноо	40%	40 оноо
5	Нийт оноо	100%	100 оноо

### Хичээлийн төгсгөлд хүрэх үр дүн:

<b>Мэдлэг – L3 түвшинд</b>	
K1	Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламжид хүчирхийлэл, түрэмгийллийн талаарх мэдлэгтэй болно
K2	Сувилагч үйлчлүүлэгчийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох, эрсдлийн талаарх мэдлэгтэй болно
K3	Сувилагч үйлчлүүлэгчийн сэтгэцийн эрүүл мэндийн байдалд эрсдлийн үнэлж, эрсдлийн бууруулах төлөвлөгөө боловсруулах мэдлэгтэй болно
K4	Дистрессийн эмгэгийг оношлох аргууд, оношлогоо, эмчилгээний талаарх мэдлэгтэй болно
K5	Зонхилон тохиолдох эмгэгийг оношлох аргууд, оношлогоо, эмчилгээний талаарх мэдлэгтэй болно
K6	Хурц байдлын үеийн хямралын төлөвлөгөөний талаарх мэдлэгтэй болно
K7	Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээний чанарын талаарх мэдлэгтэй болно
K8	Аюулгүй орчинг сэтгэцийн эрүүл мэндийн тасагт бий болгох талаарх мэдлэгтэй болно
<b>Чадвар – L3 түвшинд</b>	
S1	Хүчирхийлэл, түрэмгийлэл, бусдад аюултай үйлдэл, оргох, сэтгэц хөдөлгөөний дошгирол, мансууруулах бодисын цочмог хордлого, хоолноос татгалзах, уналт, таталтын байдал эмгэгүүдийн үеийн үеийн сувилгааг хийх чадвар эзэмшинэ
S2	Дистресс эмгэгийн үеийн үнэлгээг хийх чадвар эзэмшинэ
S3	Орчны аюулгүй байдлыг үнэлэх чадвар эзэмшинэ
S4	Сэтгэцийн эмгэгтэй хүний орчны стандарт
S5	Эрсдлийг бууруулах төлөвлөгөөг боловсруулах чадвар эзэмшинэ
S6	Нотолгоонд суурилсан сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх чадвар эзэмшинэ
S7	Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламжийн аюулгүй тасгийн хяналт, үнэлгээг хийх чадвар эзэмшинэ
S8	Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлэхэд багаар ажиллах чадвар эзэмшинэ
S9	Тухайн хүнийг энэрэхүйн, шүүмжлэхгүй, буруутгахгүйгээр тусламж үзүүлэх чадвар эзэмшинэ
<b>Хандлага – L3 түвшинд</b>	
A1	Сэтгэцийн эмгэгтэй үйлчлүүлэгчдийн үнэт зүйлсийг эрхэмлэн харилцах
A2	Үйлчлүүлэгчийг бүрэн сонсох чадвар эзэмшинэ
A3	Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай үйлчлүүлэгчид тусламж үзүүлэхдээ чин сэтгэлээсээ, хөнгөн шуурхай үйлчилж, хандах
A4	Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай үйлчлүүлэгч, тэдний ар гэрийнхэнтэй харилцааны тохирох аргыг сонгож, эерэг харилцааг бий болгох
A5	Үйлчлүүлэгчид туслах гэж буйгаа мэдрүүлэх
A6	Аливаа асуудалд багаараа хамтран шийдвэрлэх
A7	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд оролцогч талуудын эрх, үүргийг мөрдөх
A8	Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай үйлчлүүлэгчтэй харилцахдаа тэдний байр сууринд өөрийгөө тавьж, асуудалд хандах

### **ТАВ. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ**

Сувилахуйн сургалтын заах арга зүй нь суралцагч төвтэй сургалтын технологид тулгуурлан суралцагчийн бие даах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ. Сургалт нь лекц, дадлага, семинар, бие даалт гэсэн хэлбэрээр явагдана.

#### ***Лекц***

Хөтөлбөрийн дагуу сургалтын шинэлэг аргуудыг ашиглан өгүүлэх, тайлбарлах, уншуулах, эрэл хайгуул хийлгэх, үзүүлэн таниулах, асуудал дэвшүүлж шийдвэрлүүлэх, интерактив лекц, боловсролын технологийг ашиглан онлайн, цахим сургалт, видео хурал зэрэг хэлбэрүүдээр явуулах

#### ***Дадлага***

Интерактив арга барилд тулгуурлан оюутны идэвхитэй оролцоог нэмэгдүүлэх үүднээс дадлагын хичээлийг сувилагч багш нар удирдан явуулна. Эмнэлзүйн ур чадвар эзэмшүүлэх төв бүх шатны эмнэлгийн тасаг, нэгж дээр сургалтын хэрэгсэл, багаж материал, дуураймал хүн дээр практик дадлага хийлгэх, үйлчлүүлэгчийн орны дэргэдэх сургалтын арга зүйг багш, эмнэлгийн мэргэжилтний хяналтан дор дагалдах хэлбэрээр үйлчлүүлэгчтэй харилцаж ажиллана.

#### ***Семинар***

Хөтөлбөрийн дагуу сэдвүүдээр тэмдэглэл хөтлөх, LBL, дүрд тоглох бие даалган уншуулж, кейс судалгаа, эгзэгтэй тохиолдлууд, рефферат, эссе бичүүлж, видео кино үзэх, асуудалд суурилсан хэлбэрээр суралцах явцад асуудлыг шийдэх байдлыг бүрдүүлэх, багаар ажиллах, эмнэл зүйн ур чадварын хэлэлцүүлэг хийх, багаараа нийгмийн чиглэлээр ашиглаж болох нэг шинэлэг аргыг практикт нэвтрүүлэх зэрэг хэлбэрүүдээр явуулах

#### ***Сонгон суралцах***

Суралцагч өөрийн сонгосон хичээлийг хөтөлбөрийн дагуу сэдвүүдээр тэмдэглэл хөтлөх, LBL, дүрд тоглох бие даалган уншуулж, кейс судалгаа, эгзэгтэй тохиолдлууд, рефферат, эссе бичүүлж, видео кино үзэх, асуудалд суурилсан хэлбэрээр суралцах явцад асуудлыг шийдэх байдлыг бүрдүүлэх, багаар ажиллах, эмнэл зүйн ур чадварын хэлэлцүүлэг хийх, багаараа нийгмийн чиглэлээр ашиглаж болох нэг шинэлэг аргыг практикт нэвтрүүлэх зэрэг хэлбэрүүдээр явуулах

#### ***Бие даалт***

Хөтөлбөрт тусгагдсан сэдвүүдээр бие даалган эрэл хайгуул хийлгүүлж судлуулах, дадлагын хичээлийн явцад эмнэлгийн ажилтнуудтай баг болгон тасагт ажиллуулж мэдлэг, чадварыг нь бататган сурах арга барилыг дэмжиж, онол, практикийн уялдаа холбоог дэмжих, нотолгоонд суурилсан, олон янзын аргуудыг дүгнэж хичээлийн төгсгөлд тайлан бичүүлж, биечлэн хийлгэж хамгаалуулан дүгнэнэ.

### ***Үйлчлүүлэгчийн үзүүлэх буюу, эмнэл зүйн тохиолдол танилцуулах***

Эмнэлзүйн харилцааны ур чадвар эзэмшүүлэх, бие даалган үйлчлүүлэгтэй харилцах, эмнэлзүйн тохиолдол дээр ажиллуулж мэдлэг, чадварыг нь бататган, дүгнэж хичээлийн төгсгөлд сувилахуйн карт бичүүлж, биечлэн хийлгэж хамгаалуулан дүгнэнэ.

### ***Эмнэлгийн тасаг нэгжид жижүүрт гарах***

Хөтөлбөрийн дагуу бие даан суралцах, гардан үйлдлийг хийх чадварт суралцах зорилгоор эмнэлгийн тасгуудад хувиарийн дагуу жижүүрт дадлагын багш, эмнэлгийн мэргэжилтний хяналтан дор дагалдах гарна.

### ***Цахим сургалтын хүрээнд:***

- Гадаад болон дотоодын хамтын ажиллагаатай байгууллагуудтай багш нар, суралцагчид телеконференц зохион байгуулах;
- Аудио, видео, мультимедиа хичээлүүдийг суралцагчдад хүргэх;
- Суралцагчид ..... @pti.mnnums.edu.mn гэсэн өргөтгөлтэй майл хаягтай. Энэхүү майл хаягийг групп үүсгэн хэсэг, дамжаагаар нэгдсэн цахим шуудан явуулах болон мэдээ, мэдээлэл дамжуулах;
- Мүүдл (Moodle) системийг ашиглан компьютерт суурилсан online явцын болон улирлын шалгалтуудыг авах;

### **ЗУРГАА. СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ**

Үнэлгээ нь суралцагчийн ур чадвар, сургалтын үр дүнтэй холбоотой ахиц дэвшил, амжилтыг хэмжих боломжийг олгоно. Суралцагч сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан, хичээлийн кредит цагийг биелүүлсэн байна. Онол, дадлага, бие даалт, семинарийн хичээлүүдийн үнэлгээ тус бүрээр авсан рейтинг оноо 80% ба түүнээс дээш тохиолдолд үнэлгээг тооцох ба түүнээс доогуур үнэлгээ авсан тохиолдолд журмын дагуу дахин шалгалтыг товлосон хугацаанд өгч тооцуулна.

### **Дадлагын хяналт**

Эмнэлзүйн дадлыг зохих туршлагатай сэтгэцийн эрүүл мэндийн сувилагчийн хяналтан дор хийх суралцагч эмнэлзүйн дадлагын туршлагыг олж авах боломжийг олгоно. Дадлагын удирдагч багш нь суралцагчийг эмнэлзүйн дадлагын үе шатанд удирдан чиглүүлэх, дадлагын төгсгөлд суралцагчийг дадлага хийх чадварыг үнэлэх үүрэгтэй бөгөөд дадлагын хугацаанд суралцагчийн аюулгүй байдлыг хамгаалах үүрэг хариуцлага, зохих ёсоор харьцаж байх ёстой.

### Багш суралцагчийн харьцаа

Эмнэлзүйн дадлагын хугацаанд хяналт тавих, үнэлэх стратегийг үндэслэн нэг хичээлийн хамгийн тохиромжтой 12 суралцагч байх, харин багш, суралцагчийн хамгийн тохиромжтой харьцаа 1: 8-аас хэтрэхгүй байх ёстой.

### Үнэлгээний хэлбэрүүд:

Мэдлэгийг үнэлэх шалгалт	Ур чадварыг үнэлэх	Цогц чадамжийг үнэлэх
<ul style="list-style-type: none"> <li>– Аман шалгалт</li> <li>– Эссэ бичих, бичгэн шалгалт</li> <li>– Олон хувилбарт сорил</li> <li>– Практикт тохиолдолд суурилсан сорил</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>– Гардан үйлдлийг шалгалт</li> <li>– Практик тохиолдолд суурилсан гардан үйлдлийн шалгалт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>– Өртөөчилсөн шалгалт</li> <li>– Гардан үйлдлийн гүйцэтгэлийн ажиглалтын үнэлгээ</li> </ul>

Сорил, кейс сорил, DOPS, ажиглан дүгнэх, ярилцлага хэлбэрээр мэдлэг чадвар хандлагыг хяналтын үсгэн ба тоон үнэлгээгээр дүгнэнэ.

1. Мэдлэг, чадвар, хандлагын түвшинг сорил, бичиглэл, ярилцлага, бодлого зэрэг шалгалтын оновчтой хэлбэрийг ашиглан тогтооно.
2. Хөтөлбөрийн шаардлагыг 80%-аас дээш хувь хангасан тохиолдолд төгсөлтийн шалгалтанд оруулна.
3. Төгсөлтийн шалгалтыг онол, дадлага хэлбэрээр авах бөгөөд онолын шалгалтыг



сорил, бодлого, ярилцлага хэлбэрээр, ур чадвар буюу хандлагын шалгалтыг сургалтын явц болон төгсгөлд клиникт ажилласан, гардан үйлдэл хийх ур чадварыг шалган үнэлнэ.

4. Төгсөгчдийн мэдлэг, ур чадвар, хандлагыг хяналтын үсгэн ба тоон, рейтингээр дүгнэнэ.

**Ерөнхий үнэлгээ:**

№	Үнэлгээ хувиар	Үсгэн үнэлгээ	Үнэлгээний оноо(0-4)	Үнэлгээний болзол
1	90-100	A	4.0	Тухайн хичээлийн агуулгыг бүрэн бүтээлчээр ойлгож, мэдлэг эзэмшсэн, эзэмшсэн мэдэлгээ чадварлаг ашиглаж чаддаг байх
2	80-89	B	3.0	Тухайн хичээлийн агуулгыг сайн ойлгож, мэдлэг эзэмшсэн, эзэмшсэн мэдэлгээ үйл ажиллагаандаа хэрэглэж чаддаг байх
3	70-79	C	2.0	Тухайн хичээлийн агуулгыг хангалттай хэмжээний ойлголт, авсан, холбогдох энгийн даалгаварыг хийж гүйцэтгэх чадвартай бөгөөд цаашдаа тухайн хичээлийг гүнзгийрүүлэн судлах бэлтгэлтэй болсон байх
4	60-69	D	1.0	Тухайн хичээлийн агуулгыг жигд ойлгоогүй харьцангуй хялбар ажилбаруудыг хийж гүйцэтгэх чадвартай бөгөөд цаашдаа тухайн хичээлийг гүнзгийрүүлэн судлахын тулд нэмэлт даалгавар хийж гүйцэтгэх шаардлагатай
5	0-59	F	0.0	Мэдлэг, чадвар, дадал хангалтгүй байх

A. Явцийн үнэлгээг дараах байдлаар үнэлнэ.

№	Үзүүлэлт	Авбал зохих рейтинг оноо / авбал зохих оноог тавьж өгнө/	Авсан рейтинг оноо
1	Лекцийн ирц	5%	
2	Дадлага	30%	
3	Семинар	30%	
4	Бие даалт	15%	
5	Тайлан шүүлэг	20%	
	Нийт оноо	100%	

Б. Төгсөлтийн шалгалтыг онол, дадлагын хэлбэрээр авна.

Мэдлэгийн үнэлгээг сорилын шалгалтаар авна.

№	Суралцагчийн овог нэр	Тайлан хамгаалатын дүн	Явцын үнэлгээ	Дадлага шалгалтын үнэлгээ	Онолын шалгалтын үнэлгээ	Нэгдсэн үнэлгээ

В. Бие даалтын үнэлгээ

Эсээг рубрикийн аргаар үнэлэх хүснэгт

Үзүүлэлт	1-р түвшин : БИЕ даан суралцахуйн цагийг үл тооцно	2-р түвшин: БИЕ даан суралцахуйн 8 цагийг тооцно	3-р түвшин: БИЕ даан суралцахуйн 16 цагийг тооцно	4-р түвшин : БИЕ даан суралцахуйн 16 цагийг тооцно
Сэдэв сонирхол татахуйц : <b>ӨГСӨН</b> сэдвийг “өөрийнхөөр сольж бичнэ”	Бичиж буй эсээний утгыг илэрхийлж бичээгүй	Бичиж буй эсээний утгыг оновчтой илэрхийлээгүй, урт бичигдсэн	Бичиж буй эсээний утгыг илэрхийлсэн, товч бичсэн	Бичиж буй эсээний утгыг бүрэн илэрхийлсэн, товч, сонирхол татахуйц
Уншсан номоос баримт, нотолгоо, ишлэл , зүүлт хэрэглэсэн байдал	Эсээний тухайн хэсэгт үг, өгүүлбэр, санааг дэмжсэн, дэлгэрүүлсэн, тодотгосон, баталсан, нотолсон баримт, ишлэл, зүүлтийг оновчтой сонгож хэрэглээгүй	Эсээний тухайн хэсэгт үг, өгүүлбэр, санааг дэмжсэн, дэлгэрүүлсэн, тодотгосон, баталсан, нотолсон баримт, ишлэл, зүүлтийг сонгож хэрэглэсэн боловч зарим нь оновчтой бус	Эсээний тухайн хэсэгт үг, өгүүлбэр, санааг дэмжсэн, дэлгэрүүлсэн, тодотгосон, баталсан, нотолсон баримт, ишлэл, зүүлтийг ихэнх тохиолдолд онож сонгож хэрэглэсэн	Эсээний тухайн хэсэгт үг, өгүүлбэр, санааг дэмжсэн, дэлгэрүүлсэн, тодотгосон, баталсан, нотолсон баримт, ишлэл, зүүлтийг оновчтой сонгож хэрэглэсэн
Авсан ишлэлээ дугаарлаж, ашигласан ном, киноны	Хуудасны ард талд ашигласан ном, киноны жагсаалт гаргаагүй	Хуудасны ард талд ашигласан ном, киноны жагсаалт зөв гаргаагүй,	Хуудасны ард талд ашигласан ном, киноны жагсаалт нь эсээний ишлэлтэй	Хуудасны ард талд ашигласан ном, киноны жагсаалт нь эсээний ишлэлтэй яг тохирч, зөв дугаарласан

жагсаалт гаргасан эсэх		дугаарлаагүй, буруу бичигдсэн	тохироогүй, зөв дугаарлаагүй	
Эсээний бүтэц буюу эхлэл, гол, төгсгөл	Эсээний эхлэл, гол, төгсгөл хэсгийг гаргахдаа уялдаа холбоог харгалзаагүй, хоорондын зааг нь тодорхой бус	Эсээний эхлэл, гол, төгсгөл хэсгийг гаргасан боловч хоорондын уялдаа холбоог сайн гаргаж чадаагүй	Эсээний эхлэл, гол, төгсгөл хэсгийг тодорхой ялгарахаар болон хоорондын уялдаа холбоог гаргаж чадсан	Эсээний эхлэл, гол, төгсгөл хэсгийг тодорхой ялгарахаар болон хоорондын уялдаа холбоонд нь оновчтой гаргаж чадсан
Найруулга буюу үг, хэллэг, өгүүлбэр, цогцолборын сонголт	Эсээг найруулахдаа үг, өгүүлбэр, оновчтой сонгож чадаагүй	Эсээг найруулахдаа үг, өгүүлбэр, сонгож чадсан	Эсээг найруулахдаа ихэнх үг, өгүүлбэр, онож сонгосон	Эсээний найруулгад үг, өгүүлбэр оновчтой сонгож чадсан
Санаагаа хэр зэрэг илэрхийлсэн байдал	Өөрийн үзэл бодол, үнэлэмж хандлагыг сайн илэрхийлж чадаагүй	Өөрийн үзэл бодол, үнэлэмж хандлагыг зарим талаар илэрхийлж чадсан	Өөрийн үзэл бодол, үнэлэмж хандлагыг илэрхийлж чадсан	Өөрийн үзэл бодол, үнэлэмж хандлагыг үнэмшилтэй илэрхийлж чадсан
Бичгийн соёл буюу зөв бичих дүрэм, цэг тэмдгийн хэрэглээ	Зөв бичих дүрмийн хэд хэдэн алдаа гаргаж, зохих цэг тэмдгийг эрэглээгүй	Зөв бичих дүрмийн зарим алдаа гаргасан, зохих цэг тэмдгийг ихэнхдээ хэрэглэсэн	Зөв бичих дүрмийн алдаагүй, зохих цэг тэмдгийг хэрэглэсэн	Зөв бичих дүрмийн алдаагүй, зохих цэг тэмдгийг онож хэрэглэсэн
Сэдэв, өөрийн нэрээ зөв газарт бичиж, гарын үсгээ зурсан	Буруу хийсэн	Хагас дутуу хийсэн	Зарим алдаа гаргаж, гүйцэд хийгээгүй	Сэдэв голд эсвэл баруун дээд өнцөгт, гарын үсэг зүүн доод Гүйцэд, зөв хийсэн

Эмнэлзүйн дадлага шалгалтыг тусгайлан бэлтгэсэн дүгнэх хуудсыг ашиглана.

Дадлага ур чадварын шалгалтыг хөтөлбөрийн дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

№	Үнэлгээний шалгуурууд	Рейтинг оноо (0-100)	Авсан рейтинг оноо (0-100)
1.	Мэдлэг ✓ Үйлчлүүлэгчдэд үнэлгээ зөв өгч буй эсэх	10	

	✓ Үйлчлүүлэгчийг зөв оношлож буй эсэх	20	
	✓ Үйлчлүүлэгчдэд сувилгааны төлөвлөгөө зөв төлөвлөсөн эсэх	10	
2.	<b>Чадвар</b>		
	✓ Өгөгдсөн тохиолдол дээр ажиллуулж гардан үйлдлийн чадварыг дүгнэх	20	
	✓ Тасагт ажиллах гардан үйлдлийн үнэлгээ	20	
	✓ Үйлчлүүлэгчдэд зөв гардан үйлдэл гүйцэтгэж буй эсэх	10	
	✓ Үйлчлүүлэгч, түүний ар гэрт тохирох зөвлөгөөг өгч чадаж буй эсэх		
	✓ Үйлчлүүлэгчтэй эргэх холбоо үүсгэж чадаж буй эсэх		
3.	<b>Хандлага</b>		
	✓ Үйлчлүүлэгчдтэй зөв харилцаа үүсгэж буй эсэх	10	
	<b>Бүгд авсан рейтинг оноо</b>	<b>100</b>	

Дараах үнэлгээний аргуудыг ашиглана.

### Эмнэлзүйн ур чадварын үнэлгээ (Mini-CEX)

Энэхүү үнэлгээ нь: эмнэлзүйн ярилцлага хийх, эмнэл зүйн үзлэг хийх үед суралцагчийн ярилцлага хийх ур чадвар, бодит үзлэг хийх ур чадвар, эмнэл зүйн сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх чадвар, зөвлөгөө өгөх, зохион байгуулах зэрэг цогц чадамжийг нэгэн зэрэг үнэлдэг 9 онооны системээр үнэлдэг арга юм. Зураг 1.

Үүнд:

- 1-3 оноо нь хангалтгүй
- 4-6 оноо нь хангалттай
- 7-9 оноо нь хангалттай маш сайн

### Үнэлгээний загвар хуудас (Mini-CEX)

Шалгалт авсан .....он .....сар .....өдөр

Шалгагчийн нэр: .....

Шалгуулагчийн нэр .....овог .....нэр

Шалгалт авсан орчин (доогуур нь зур): Тасагт, амбулаторид, стандарт өвчтөн, бусад

Үйлчлүүлэгчийн нас ....., хүйс: эр/эм (доогуур нь зур)

Үзлэг(доогуур нь зур): анх удаа, давтан

Үйлчлүүлэгчийн биеийн байдал(доогуур нь зур): хүнд, дунд зэрэг, хөнгөн

Шалгалтын зорилго: .....

1. Асуумж авах ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)

1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		

2. Бодит үзлэг хийх ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)

1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		

3. Эмнэлзүйн сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)

1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		

4. Зөвлөгөө өгөх ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)

1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		

5. Үр дүнтэй зохион байгуулах ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)

1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		

6. Үйлчлүүлэгчид тавьж буй анхаарал, хүнлэг байдал (ажиглагдаагүй бол 0 оноо)

1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		

7. Ерөнхий эмнэлзүйн ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)

1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		

Шалгагч багшийн зүгээс Mini-CEX үнэлгээнд өгөх сэтгэл ханамж:

(1-9 оноог өгнө) .....

Шалгуулагчийн зүгээс Mini-CEX үнэлгээнд өгөх сэтгэл ханамж:

(1-9 оноог өгнө) .....

Тэмдэглэл: .....

### Гардан үйлдлийн үнэлгээ (DOPS)

Энэхүү гардан үйлдлийн үнэлгээ нь: эмнэлгийн нөхцөлд хийгддэг ажилбарыг ажиглах замаар үнэлж дүгнэдэг арга юм. Өвчтөний дэргэд эсвэл эмнэлзүйн дуураймал орчинд шалгуулагчийн техник ур чадварыг 15-25 минутын хугацаанд 9 онооны системээр үнэлдэг арга юм. Зураг 2.

Үүнд:

- 1-3 оноо нь хангалтгүй
- 4-6 оноо нь хангалттай
- 7-9 оноо нь хангалттай маш сайн

### Үнэлгээний загвар хуудас (DOPS)

Шалгалт авсан .....он .....сар .....өдөр

Шалгагчийн нэр: .....

Шалгуулагчийн нэр .....овог .....нэр

Шалгалт авсан орчин (доогуур нь зур): Тасагт, амбулаторид, стандарт өвчтөн, бусад

Үйлчлүүлэгчийн нас ....., хүйс: эр/эм (доогуур нь зур)

Үзлэг(доогуур нь зур): анх удаа, давтан

Үйлчлүүлэгчийн биеийн байдал(доогуур нь зур): хүнд, дунд зэрэг, хөнгөн

Гардан үйлдлийн нэр: .....

1. Хийж буй үйлдлийн техник болоод холбогдох ойлголтуудыг мэдэж буй  
байдал (ажиглагдаагүй бол 0 оноо)

1            2            3            4            5            6            7            8            9

Хангалтгүй

Хангалттай

Маш сайн

2. Үйлчлүүлэгчээс холбогдох зөвшөөрлийг авсан эсэх  
(ажиглагдаагүй бол 0 оноо)

1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		

3. Гардан үйлдлийн өмнөх бэлтгэл ажил (ажиглагдаагүй бол 0 оноо)

1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		

4. Тайвшруулах ба сэтгэц нөлөөт эм бэлдмэлийг зөв сонгож, тун зөв эсэх,  
бэлтгэх (ажиглагдаагүй бол 0 оноо)

1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		

5. Техник ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)

1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		

6. Халдваргүйжүүлэх техник ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)

1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		

7. Зөв зохистой тусламж үйлчилгээг үзүүлэх ур чадвар  
(ажиглагдаагүй бол 0 оноо)

1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		

8. Гардан үйлдлийн дараах менежмент (ажиглагдаагүй бол 0 оноо)

1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		

9. Харилцааны ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)

1	2	3	4	5	6	7	8	9
---	---	---	---	---	---	---	---	---

Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		
10. Өвчтөнд тавьж буй анхаарал ба хүнлэг байдал (ажиглагдаагүй бол 0 оноо)								
1	2	3	4	5	6	7	8	9

Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		
11. Үйлдлийг гүйцэтгэх ерөнхий ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)								
1	2	3	4	5	6	7	8	9

Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		
------------	--	--	------------	--	--	----------	--	--

Шалгагч багшийн зүгээс Mini-CEX үнэлгээнд өгөх сэтгэл ханамж:

(1-9 оноог өгнө) .....

Шалгуулагчийн зүгээс Mini-CEX үнэлгээнд өгөх сэтгэл ханамж:

(1-9 оноог өгнө) .....

DOPS үнэлгээ хийсэн хугацаа: 1. Ажигласан хугацаа ..... мин

2.Эргэх үнэлгээ ..... мин

Тэмдэглэл: .....

### Үнэлгээний загвар хуудас (360 хэмийн үнэлгээ)

Шалгалт авсан .....он .....сар .....өдөр

Шалгуулагчийн нэр .....овог .....нэр

1. Эмнэлгийн ажилтантай харилцах хандлага: хүндэтгэлтэй, харилцан ойлголцож харилцаж байгаа байдал								
1	2	3	4	5	6	7	8	9

Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		
------------	--	--	------------	--	--	----------	--	--

2. Үйлчлүүлэгчтэй харилцах хандлага: итгэл найдвартай, үйлчлүүлэгчдийн эрх болон хийх эрхийг хүндэтгэн үздэг эсэх								
1	2	3	4	5	6	7	8	9

Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		
------------	--	--	------------	--	--	----------	--	--

3. Найдвартай нягт нямбай байдал



1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		

4. Харилцааны ур чадвар: Үйлчлүүлэгч болон тэдний гэр бүлтэй харилцах

1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		

5. Харилцааны ур чадвар: эмнэлгийн мэргэжилтэн, ажилтантай харилцах

1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		

6. Багаар ажиллах ур чадвар: хариуцлагатай, шуурхай, нэгнээ дэмжих байдал

1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		

7. Манлайлах ур чадвар: өөрийн болоод багийн хийж буй ажилд хариуцлагатай, идэвхитэй оролцох

1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		

8. Ерөнхий харилцаа, хандлагын байдал

1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		

Тэмдэглэл: .....

## **ДОЛОО. АШИГЛАХ НОМ СУРАХ БИЧИГ, ГАРЫН АВЛАГА БУСАД**

### **Холбогдох хууль тушаал, стандарт**

1. Монгол улсын хууль “Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль / шинэчилсэн найруулга 2013/
2. “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хууль 2000 он (2003 оны 11 сар, 2017 оны 12 сарын шинэчилсэн найруулга)
3. “Сэтгэцийн эрүүл мэнд Үндэсний хөтөлбөр”- 2000, 2009

4. Түгээмэл үйлдлийн стандарт MNS4621:2008.
5. “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ” ЭМС-ын 2006 оны 135 тоот тушаалын 3-р хавсралт
  1. “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэнд хяналт тавих тухай” хууль - 2002 он (2011 оны 5 сард шинэчлэн найруулсан)
  2. “Тамхины хяналтын тухай” хууль 2005 он (2012 оны 10 сар, 2015 оны 12 сарын шинэчилсэн найруулга)
  3. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ УБ 2006 406 тоот тушаал
  4. Хүн амын зонхилон тохиолдох сэтгэц ба зан үйлийн эмгэг, сэтгэл зүйн оношлогоо, эмчилгээ, өөрийгөө сургах дасгал, харилцан нөлөөллийн бүлгийн сэтгэл заслын стандарт (MNS 5481-1-9:2005, 5934-5939:2008),
  5. Сэтгэц нөлөөт бодисын улмаас үүсэх сэтгэц ба зан үйлийн эмгэгийн оношлогоо, эмчилгээний стандарт (MNS 5396:1-10:2014),
  6. Нийгэмд аюултай үйлдэл хийж болзошгүй сэтгэцийн эмгэгтэй хүнд хэрэглэх тусгаарлах болон номхотгох аргын жагсаалт, тэдгээрийг хэрэглэх журам /ЭМС-ын 2014 оны №180 тоот тушаал/ УБ 2014
  7. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг 3 шатлал дах ЭМБ-ын бүтэц, үйл ажиллагааны стандарт (ӨЭМТ-MNS 5292:2017, Нэгдсэн эмнэлэг-MNS 5095:2017, Төрөлжсөн төв эмнэлэг-MNS 6330:2017)
  8. ЭМС-ын 2019 оны “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм” А/406 дугаар
  9. МУ-ын “Тогтвортой хөгжлийн зорилт- 2030”
  - 10.Х.Дамдинжав “Анагаах ухааны ёс зүйн хураангуй” Тайлбар толь, УБ хот, 2016 он
  - 11.Ким Жинь Хый “Сувилахуйн ёс зүй” 2019 он

#### **ДЭМБ-ын зөвлөмжүүд**

1. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламжийн тухай хууль 10 үндсэн зарчим ДЭМБ. Женев. 1996
2. Сэтгэцийн өвчтэй хүмүүсийг хамгаалах ба сэтгэцийн эрүүл мэндийн тусламжийг сайжруулах талаар баримтлах 25 зарчим НҮБ-ийн Ерөнхий Ассамблей 1971 онд батлагдсан.

#### **Үндсэн сурах бичиг**

1. С.Бямбасүрэн Сэтгэцийн өвчтэй хүмүүсийн сувилахуй ба сэтгэц нийгмийн реабилитаци. УБ., 1999

2. Л.Эрдэнэбаяр Сэтгэцийн эрүүл мэнд., УБ. 2008
3. Л.Эрдэнэбаяр Донтох эмгэг судлал., УБ 2009
4. С.Бямбасүрэн “Сэтгэцийн эмгэг судлал” УБ.,2007, 2015
5. С.Сэргэлэнчимэг., С.Дэлгэрмаа нарын “Төрөлжсөн сувилахуйн -I” УБ.,2011
6. З.Хишигсүрэн “Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуй” УБ.,2012
7. З.Хишигсүрэн “Сэтгэцийн эрүүл мэндийн төрөлжсөн сувилахуй” УБ.,2013
8. З.Хишигсүрэн., С.Дэлгэрмаа нарын “Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн үеийн сувилахуйн тусламж, үйлчилгээний эмнэлзүйн удирдамж” УБ., 2014
9. С.Сэргэлэнчимэг., С.Дэлгэрмаа нарын “Төрөлжсөн сувилахуйн -II” УБ.,2015
- 10.С.Дэлгэрмаа., Л.Одгэрэл нарын “Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн хичээлийн гарын авлага” УБ.,2015
- 11.З.Хишигсүрэн., Х.Тэргэл., Х.Эрдэнэбаатар “Сэтгэцийн синдром” УБ., 2020
- 12.Ц.Гүрдорж., З.Хишигсүрэн “Ерөнхий сэтгэц судлал” УБ., 2020
- 13.ЭМЯ, СЭМҮТ, АШУҮИС багш нарын хамтарсан “Амиа хорлох төрх үйлээс урьдчилан сэргийлэх нь” гарын авлага УБ., 2020
- 14.ЭМЯ, СЭМҮТ багийн хамтарсан “Хүчирхийллийн хохирогч ба үйлдэгчдэд үзүүлэх сэтгэлзүйн тусламж үйлчилгээ” эмнэлзүйн гарын авлага УБ., 2020

#### **Туслах сурах бичиг**

1. С.Бямбасүрэн “Мансуурал судлал” УБ., 1999
2. Сэтгэцийн эрүүл мэндийн нийгэмлэг.“Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, өвчтөн гэр бүлийнхний оролцоо” УБ., 2005
3. Л.Эрдэнэбаяр “Сэтгэцийн эрүүл мэнд” УБ.,2008
4. Л.Эрдэнэбаяр. "Донтох эмгэг судлал" .УБ.,2009
5. Н.Орёл, Л.Насанцэнгэл “Сэтгэцийн эмгэг судлал” УБ., 2009
6. Н.Оюунчимэг, Л.Насанцэнгэл, О.Ганчулуун, Л.Эрдэнэбаяр “Сэтгэцэд нөлөөт эмийн зохистой хэрэглээ, эмийн бус эмчилгээний аргууд” УБ., 2010
7. Л.Эрдэнэбаяр “Сэтгэцийн эмчийн өврийн дэвтэр” УБ.,2010
8. Л.Эрдэнэбаяр “Сэтгэцийн эрүүл мэнд судлалын лекцүүд” УБ.,2011
9. ДЭМБ, Европын холбоо, СЭМҮТ “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамт олонд түшиглэн сэргээн засах хандлага ба сэтгэцийн эрүүл мэнд” УБ., 2013
- 10.ДЭМБ, Европын холбоо “Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагын удирдамж” УБ., 2013

11. Лурдес Ладридо Илнасию М.Д, Ансельмо Т.Тронию М.Д “Нийгэм хамт олонд тулгуурласан сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ” УБ.,2013

12. Л.Эрдэнэбаяр “Сэтгэл засал эмчилгээ” УБ., 2019

**Вейб сайтыг хаягууд:**

- [www.moh.mn](http://www.moh.mn)
- [www.who.org](http://www.who.org)
- [www.unicef.org](http://www.unicef.org)
- [www.medscape.com](http://www.medscape.com)
- [www.pubmed.com](http://www.pubmed.com)
- [www.aap.org/family/famhome.htm](http://www.aap.org/family/famhome.htm)
- [www.psyllive.ru](http://www.psyllive.ru)
- [www.psychology.su](http://www.psychology.su)
- [www.themedguru.com](http://www.themedguru.com)
- <http://commune.hi.is/>
- <https://correctionalnurse.net/how-to-perform-a-psychiatric-nursing-assessment/>
- <https://online.regiscollege.edu/blog/7-mental-health-evidence-based-practices-nursing>

## **НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН ЧАНАРЫН БАТАЛГААЖИЛТ**

### **Чанарын хяналт, үнэлгээ**

Хичээлийн чанар, стандартыг үнэлэхэд хөндлөнгийн аудит нь зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ нь сургалтын хөтөлбөрийн загвар, заах /сургах аргууд, суралцагчийн үнэлгээ, үр дүнгийн тэмдэглэл, сургалтын явцад сургалтын үр дүнд нотлогдсон байна. Сургалтын хөтөлбөрийн үнэлгээг багш, суралцагч, үйлчилгээ үзүүлж буй сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн мэргэжилтнүүд, сэтгэцийн эрүүл мэндийн сувилагч мэргэжилтнүүд хийнэ. Хөтөлбөрөөр суралцах хугацаанд мөрдөх дүрэм, журам нь суралцагчийн бие даан амжилттай суралцахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжсэн, хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцэхүйцээр боловсруулсан байна.

### ***Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн үнэлгээ, тайлагналт***

Хөтөлбөрөөр суралцах хугацаанд мөрдөх дүрэм, журам нь суралцагчийн бие даан амжилттай суралцахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжсэн, хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцэхүйцээр боловсруулсан байна.

### ***Дотоодын чанарын баталгаажуулалт ба сайжруулалт***

Сургалт зохион байгуулж буй сургалтын байгууллага нь сургалтын чанарыг баталгаажуулж, чанараа илтгэн харуулж, хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлэх үүрэгтэй юм. Нийгмийн хэрэгцээ, хууль тогтоомжийн шаардлагад үндэслэн дотоод чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлнэ.

### ***Үр нөлөөллийн үнэлгээ (мэргэжлийн салбар дахь нөлөөллийн үнэлэлт)***

1. Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтыг хангах удирдлага, зохион байгуулалтын шийдэл бий болгох;
2. Дотоод чанарын баталгаажуулалтын тогтсон бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх;
3. Дотоод чанарын баталгаажуултанд хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудыг оролцуулах;
4. Хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрч чадсан эсэхийг мэдээ баримтад тулгуурлан өөрийн үнэлгээг хийдэг байдал ба хөтөлбөрийн хэрэгжилтэд эргэх холбоо үүсгэх;
5. Хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах болон хөтөлбөрт орсон өөрчлөлтүүдийн үр нөлөөг хянах;

Хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрч чадсан эсэхийг мэдээ баримтад тулгуурлан өөрийн үнэлгээг хийдэг байдал ба хөтөлбөрийн хэрэгжилтэд эргэх холбоо үүсгэх;

- Сэтгэл ханамжийн үнэлгээг төгсөгч, ажил олгогчоос авна.
- Төгсөгчдийн ажил эрхлэлт, ажлын байрны нийцлийн судалгааг гаргана.
- Явцын үнэлгээг хийнэ. Заавал судлах, мэргэшүүлэх, дадлага, сонгон судлах хичээл тус бүр дээр явцын шалгалт, онолын болон ур чадварын АШУҮИС-ийн үнэлгээний журамд заасны дагуу шалгаж, үнэлгээнд нь дүн шинжилгээ хийнэ.
- Мэргэшүүлэх хичээлүүдийг нэгдмэл байдлаар онолын болон гардан үйлдлийн шалгалтаар төгсөгчдийн суралцах хугацаандаа эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг шалгаж, 80%-иас дээш үнэлэгдсэн тохиолдолд АШУҮИС-ийг Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн мэргэшлээр төгссөн мэргэшлийн үнэмлэх олгон, хөтөлбөрийн үр дүнг тооцох;

Хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах болон хөтөлбөрт орсон өөрчлөлтүүдийн үр нөлөөг хянах;

- Төгсөн гарсан мэргэжилтний хүн амын эрүүл мэндийг хамгаалах чиглэлд ажиллах мэргэжилтнүүдийн тоо, цаашдаа салбарт гарсан өөрчлөлт, хүн амын эрүүл мэндийн сайжралтанд гарсан өөрчлөлтийг судлах зорилго тавин ажиллана.
- Хөтөлбөрт орсон өөрчлөлтүүдийн үр нөлөөг хянахдаа эрүүл мэндийн бодлогын баримт бичгүүд, түүнд гарсан өөрчлөлтүүдтэй уялдуулан судлана.

Багш бүр өөрийн үнэлгээндээ дүгнэлт хийж, үйл ажиллагааныхаа давуу болон сул талаа тодорхойлон дутагдалтай талаа давуу тал болгоход анхаарч дараагийн хичээлийн жилийн ажлын төлөвлөгөөтэй уялдуулах нь дотоод чанарын баталгаажуулалт болно.

Сургалтын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ (ажил олгогч, мэргэжилтний хөндлөнгийн үнэлэлт) хийнэ.

### **ЕС. УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, мэдээллийн системийг боловсруулан, мэдээллийн санг бүрдүүлэн, бүртгэл тооцоог цахимжуулна.

### **АРАВ. ХАРИЛЦАА ХАМТЫН АЖИЛЛАГАА**

Хөтөлбөрийг гадаад дотоодын их дээд сургуулийн төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөртэй харьцуулах боломжтой байна.

Төр, хувийн хэвшил болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, ажил олгогчтой харилцан үр дүнтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан байна.